

1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН УВС АЙМАГТАЙ ХОЛБОГДОХ ЗОРИЛТУУДЫН БИЕЛЭЛТ Ж-4.6,Х-3-

Монгол улсын засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Увс аймагтай холбогдох 96 зорилт, 170 заалт тусгагдсан бөгөөд дээрх зорилт, заалтуудыг хэлтэс агентлаг, аймгийн ЗДТГ-ын ажилтнуудад хариуцуулан өгч биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцон гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, заалтуудыг салбараар ангилан авч үзвэл эрүүл мэнд, биеийн тамир спортын чиглэлээр 10 зорилт, 19 заалт, боловсрол, соёл, хүүхдийн чиглэлээр 16 зорилт, 29 заалт, хөдөлмөр, халамж үйлчилгээ, нийгмийн хамгааллын чиглэлээр 12 зорилт, 13 заалт, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр 7 зорилт, 10 заалт, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр 7 зорилт, 12 заалт, хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр 15 зорилт, 33 заалт, байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцааны чиглэлээр 15 зорилт, 31 заалт, хууль эрх зүй, мэргэжлийн хяналтын чиглэлээр 5 зорилт, 7 заалт, төрийн захиргааны чиглэлээр 9 зорилт, 17 заалт тус тус хэрэгжиж байна.

Аймгийн хэмжээнд 2010 оны эхнээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд хэрэгжилтийн явц 2010 оны жилийн эцсийн байдлаар 61,8 хувьтай байгаа нь 2009 оны жилийн эцсээс 29,6 хувиар өссөн байна.

Гэхдээ 2009-2010 оны өвөл, хаврын зудын улмаас мал их хэмжээгээр хорогдож, олон малчин өрх амьжиргааныхаа эх үүсвэрээс салсан нь ядуурал, ажилгүйдлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хангахад сөргөөр нөлөөлж байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар ерөнхий боловсролын сургуулийг 3-р ээлжгүй болгох, газрын төлбөрийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал хүргүүлэх, аймгийн төвийн дулаан хангамжийн байдалд судалгаа хийж шинэчлэлийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрх зүйн туслалцааны төвийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн туслалцаатайгаар байгуулж, үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, төсвийн байгууллагуудын ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулан сургаж, чадавхийг бэхжүүлэх, төрийн албан тушаалын чиг үүргийн шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хүлээх үүрэг хариуцлагыг нь тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан баталж мөрдүүлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлэх, дайчилгааны 1, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын чанар, оролцох бүрэлдхүүнийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зэрэг зорилтууд зуун хувийн биелэлттэй байна.

Мөн хүзн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшинг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдад албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачлагад тулгуурлан орон нутаг, бүсийн хөгжил, салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж буй төв болон орон нутгийн байгууллагуудын ажил үүргийн зохион байгуулалтыг сайжруулж, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээ авах, “Ногоон хувьсгал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ойжуулах, мод бут, сөөг, загийг үрээр тарималжуулах, ногоон байгууламжийг эрчимжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгжийн төсөл, арга хэмжээг санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжих, согтууруулах ундааны үйлдвэрлэл үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж гаргасан санал дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авах, хил бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх таатай нөхцлийг хангах талаар холбогдох талуудтай ажиллах зэрэг зорилтуудын биелэлт 90 хувьтай биелэгдэж байна.

Харин “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлагдаагүй байгаатай холбогдуулан уг хөтөлбөртэй холбоотой 2 заалт болон хот суурин газрын цэвэрлэх байгууламжид техник технологийн шинэчлэл хийж ашиглалтыг сайжруулан, стандартын шаардлага хангуулах, тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган тухайн газар нутгийн онцлог, нөөц даацад тохируулан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх, аялал жуулчлалын

томоохон цогцолбор төв барьж байгуулах гэсэн зорилтууд 10хувь буюу хангалтгүй биелэлттэй байна.

Үүнээс гадна “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийг зарлаагүй байгаа тул энэ зорилт огт биелээгүй байна.

Засгийн газрын газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Увс аймагтай холбогдох 96 зорилт, 170 заалтын биелэлтийг 2010 оны жил эцсийн байдлаар авч үзвэл 15 заалт 100 хувь, 26 заалт 90 хувь, 49 заалт 70 хувь, 48 заалт 50 хувь, 26 заалт 30 хувь, 5 заалт 10 хувь, 1 заалт 0 хувийн биелэлттэй, дундач хувь **61,8** байна.

**Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг
хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан
Увс аймагтай холбогдох зорилтуудын
биелэлт**

2010 оны жилийн эцсийн байдлаар

Зорилт №	Заалт №	Авах арга хэмжээ	Биелэлт	хувь
1.1.1	1	Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт санхүүжилтийн механизмыг төв болон орон нутгийн түвшинд оновчтой болгоно	Нийгмийн эрүүл мэндийн талаар гарсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан жилд аймгийн Эрүүл мэндийн газрын төсөвт 49-62 сая төгрөгийн санхүүжилт олгож хөтөлбөрийн шалгуур үзүүлэлттэй үр дүнг тооцон ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 2010 онд нийт 93 удаагийн сургалт явагдсанаас ЭМЯ, төсөл хөтөлбөрийн чиглэлээр 22, орон нутгийн санхүүжилтээр 71 сургалт явагдаж 1949 эмч, эмнэлгийн ажиллагсад, эрүүл мэндийн туслагч, бусад салбаруудын холбогдох мэргэжилтнүүд, зорилтот бүлгийнхэн хамрагдлаа. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр 14-30 хоногийн хугацаатай 6 удаагийн аян зохион байгуулж Улаангом сумын 2540 иргэн хамрагдлаа.	50
	3	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын удирдамжийн дагуу эрүүл хот, дүүрэг, сум, баг ажлын байр, сургууль бий болгох үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ	Ариун цэврийн хэвийн нөхцөл хангуулах тухай аймгийн Засаг даргын 2009-04-15-ны өдрийн 136 тоот захирамжаар Жил бүрийн IV/15- V/15 хүртэл нэг сарын хугацаанд Эрүүл орчин уриан дор аймаг сумын төвийн айл өрх, төр, ТББ, аж ахуйн нэгжийн ариун нэгжийн ариун цэврийн байгууламж, муу усныцоонотг ариутгал халдваргүйтгэл, шавьжгүйтэл хийж, хашаа гудамжийг хаягжуулах ажлыг зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга, ЭМГ, МХГ-т даалгасан бөгөөд уг ажлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Эрүүл мэндийг дэмжих байгууллага шалгаруулах болзол журмын тухай ЭМС-ын 176 тоот тушаалыг харьяа сум, өрхийн эмнэлэгт хүргүүлж хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулснаар 2009 онд Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо аймагт-3, сум орон нутагт-19 байсан бол 2010 онд аймгийн эрүүл мэндийг дэмжих байгууллага болохоор болзлоо хангасан-5, сум орон нутгийн болзол хангасан-7 байгууллага байна.	50
1.1.4	1	Төлбөрийн чадваргүй амьжиргааны түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгох үр дүнтэй механизмыг судалж шийдвэрлэнэ	Аймгийн хэмжээнд төлбөрийн чадваргүй амьжиргааны түвшинээс доогуур орлоготой, ЭМД -гүй иргэд, хөдөөгийн малчдад төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг явуулын үйлчилгээгээр жил бүр үзүүлснээс гадна хөдөөгийн 62 багийн 37793 иргэдэд эрүүл мэндийн үзлэг, мэдээлэл сургалт сурталчилгаа, соёл урлаг, ахуйн үйлчилгээний явуулын багийн үйлчилгээг үзүүлсэн. Эрхийн бичгээр	50

			үйлчлэх журам боловсруулагдаагүй тул жилийн төлөвлөгөөнд тусгагдсан графикайн дагуу иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж байна. 2010 онд 12 сумын 30 гаруй мянган иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулсан.	
1.1.5	1	Эрүүл мэндийн салбарын эрх зүй санхүүгийн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоно	2008 онд онд АСОЛОУС- 3.0 санхүүгийн шинэ программыг сумдын эмнэлгийн санхүүгийн компьютерт суулгаж төрийн сантай мэдээлэл солилцож байна. Эрүүл мэндийн салбарын эрх зүй санхүүгийн механизмыг боловсронгуй болгох чиглэлээр 2008 онд 53, 2009 онд 42, 2010 онд 54 тушаал шинээр гарч ЭМД-ын сангаас санхүүжих тухай, ЭМД-ын санхүүжилтийг бүртгэх мэдээлэх, онош шинжилгээний бүртгэлийн маягт батлах тухай, төлбөртэй үйлчилгээг ЭМД-ын сангаас санхүүжүүлэх тухай, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын хяналтыг сайжруулах тухай, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг эрчимжүүлэх тухай, эмнэлгээс шалтгаалах халдварын шалтгааныг бууруулах тухай, зоонозын халдварын халдварын үед хүн, мал эмнэлгийн ажиллах журам, эрүүл мэндийн салбарын зарим мэргэжлийн эмчийн үндсэн цалинг нэмэгдүүлэх тухай,эрүүл мэндийн салбарын эмч ажиллагсадыг 40 мянган айлын орон сууцанд хамруулах тухай зэрэг эрх зүйн механизмыг боловсронгуй болгох тушаал журмын заалтыг мөрдлөг болгон ажиллаж байна.	50
	2	Эрүүл мэндийн салбарын төрийн байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх оновчтой механизмыг бүрдүүлнэ	Эрүүл мэндийн салбарт өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, төрийн оролцоог багасгах зорилгоор хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн 27 байгууллагын үйл ажиллагаагааны оролцоог дэмжин ажиллаж байна. Ортой 2 эмнэлгийг сонгон шалгаруулалтанд оруулж улмаар даатгалын тогтолцоогоор санхүүжүүлэх эрхээр хангах боломж бүрдүүлсэн. Цаашдаа ашгийн бус, улсын эмнэлгийн үзүүлж чадахгүй тусламж үйлчилгээг үзүүлдэг нийгмийн эмзэг бүлгийнхэнд үйлчилдэг төсөл хөтөлбөрт хамрагдаж, өндөр техник,технологи,эмчилгээний аргыг нэвтрүүлэн төрийн болон хувийн хэвшлийн зохистой харьцааг бий болгон ажиллахад аймгийн эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.	50
1.1.6	3	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын (төрөлжсөн мэргэжлийн, аймаг сум дүүрэг болон өрхийн эмнэлгийн) үйл ажиллагааны стандартыг шинэчилнэ	Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, сум дундын болон өрхийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартыг шинэчлэх саналыг холбогдох эмч мэргэжилтнүүдээс авч нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлсэн.	70
1.1.7	5	Аймаг бүрд 5-6 сумын дунд явуулын амбулаторийн үйлчилгээ бий болгож тоноглогдсон тээврийн хэрэгслэлээр хангана	Аймгийн нэгдсэн эмнэлгийг иж бүрэн тоноглогдсон 1, тоноглогдоогүй явуулын үйлчилгээний зориулалттай 3 машинаар хангасан байна. Нүүдлийн амбулаторийн үйлчилгээг санаачлан жил бүрийн хавар, намарт отрын айл өрхүүдээр нарийн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээг үзүүлж , давхардсан тоогоор 2500 өрхийн 56450 хүнд үйлчилгээ үзүүлсэн тооцоо гараад байна	50

	6	Өрх сумын эмнэлэг бүрийг нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багцад заасан эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амд бүрэн үзүүлэх чадавхитай болгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нь түлхүү хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	Өрх сум бүрийг нэн шаардлагатай 147 нэр төрлийн 224873234 төгрөгийн багаж тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийг эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр олгон сумын эмнэлэг бүрийг лаборанттай болгон эм урвалж бодисоор ханган ажиллаж байна. Сум өрхийн эмнэлгийн эмийн хангалт 87.2 хувьтай байна. НЭМ-ийг түлхүү хөгжүүлэх төрийн бодлогын хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр 13 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2008 онд 24 сая, 2009 онд 59 сая 2010 онд 256 сая гаруй төгрөгийн санхүүжилтийг эмнэлгийн тоног төхөөрөмжид зарцуулсан байна.	50
	7	Сумын эмнэлгийн ариун цэвэр эрүүл ахуйн стандартыг боловсруулан мөрдүүлж нөхцөлийг нь сайжруулна	Сумын эмнэлгийн ариун цэвэр эрүүл ахуйн стандартыг MNS 5082: 2005, MNS 5292: 2003 сумын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартанд эрүүл ахуйн шаардлагыг 2 зүйл, 40 заалтаар нарийвчлан зааж мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. Стандартанд орсноор сумын эмнэлгүүдийг цэвэр, бохир усны системд холбох зорилтын дагуу Өмнөговь, Тэс, Баруунтуруун, Өлгий, Хяргас сумын цэвэр бохир усны системийг засварлаж ашиглалтанд оруулсан.	50
	8	Багийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багийн бага эмчийг бэлтгэж унаатай болгоно	2009 онд Тэсийн Хар үзүүр багийн их эмчийн салбарыг машинтай, 5 сумын 11 багийн эмчийг мотоцикльтэй болгосон байна. 2010 онд Тариалан, Сагил, Хяргас, Өмнөговь сумын хөдөөгийн 14 багийн эмчийг унаажуулаад байна.	70
1.1.9	1	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнийг лабораторийн шинжилгээнд үндэслэн тандах тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлэх арга хэмжээ авна	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнийг судлах эмч мэргэжилтнийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт бэлтгэн вирусын хүрээг тодорхойлох хурдавчилсан тестээр ханган сэжигтэй илэрсэн соригцыг ХӨСҮТ-ийн вируслогийн төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын төв лаборатори Япон улсад үе шаттайгаар х үргүүлэн вирус тандалтын шинжилгээг явуулж байна.	30
	4	“Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж шинэчлэн боловсруулна	ХДХВ/ДОХ/БЗДХ-ын хянах ажлын хэсгийг 2009 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 225 тоот захирамжаар батлан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. “Увс Эрүүл хүн” хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт халдварт өвчинтэй тэмцэх асуудлыг тусгаад байна. Аймгийн ЗДТГ, ХӨСҮТ-тэй хамтран халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж холбогдох мэргэжилтнүүдэд сургалт явууллаа.	50
1.1.11	2	Алсын зайн оношлогооны сүлжээг өргөжүүлж бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг хамруулна	НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын эмч нарын нийгэмлэг хамтарч 27 сая төгрөгийн үнэ бүхий зайн оношлогооны төхөөрөмжийг Нэгдсэн эмнэлэгт суурилуулсан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн 4 их эмчийг алсын зайн оношлогоо хийх сургалтанд хамруулан тоног төхөөрөмжөөр хангаж алсын зайн оношлогоонд Нэгдсэн эмнэлэг холбогдон ажиллаж байна.	70
1.1.13	2	Аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулж хэрэгцээг харгалзан шаардлагатай тохиолдолд төрөх газар болон хүүхдийн эмнэлгийг шинээр барьж	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулах хэрэгцээг харгалзан судалгаа хийж 99 нэр төрлийн 34.967.885.00 ам долларын тоног төхөөрөмж эм урвалж НҮБ-ын ХАС -аас хүлээн авч эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад ашиглаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэд төрөх тасгийн	50

		перинатологийн төв байгуулна	барилга шинээр ашиглалтанд орууллаа.	
1.1.19	1	Биеийн тамир спортын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж биеийн тамир спортын хөгжлийг эрчимтэй хангах эрх зүйн удирдлага зохион байгуулалт санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 95 тоот тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ыг ханган биелүүлэх үүднээс Засгийн газраас биеийн тамир, спортыг 2010-2019 онд хөгжүүлэх цогц хөтөлбөрийг боловсруулах ажил анхан шатанд хэлэлцэгдэж саналаа хүргүүлсэн. Энэхүү хөтөлбөр батлагдсанаар орон нутагт биеийн тамир спортыг хөгжүүлэх үзэл баримтлал тодорхойлогдож хөгжлийг эрчимжүүлэх нөхцөл бий болно. 2010 оны жил эцсийн байдлаар аймгийн шигшээ баг 6 төрлөөр хичээллэж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын 2009 оны 04 сарын 15-ны өдрийн 137 тоот захирамжаар жил бүр аймгийн хэмжээнд “Биеийн тамир-Эрүүл мэнд” уриан дор хэлтэс, байгууллага бүр тодорхой ажил хариуцан зохион байгуулахыг даалган ажиллаж, хэрэгжилтэнд хяналт тавьж байна. Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд сум, байгууллага бүрт 7-14 хоногт тодорхой сэдвийн дагуу уралдаан тэмцээн зохион байгуулах, иргэн бүрийг хөдөлгөөнд оролцуулах ажлыг хийгээд байна. Тухайлбал:</p> <p>ЭМГазар “Идэвхтэй хөдөлгөөн хийж эрүүл амьдарцгаая” гэж уриалга гарган үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>	70
	2	Биеийн тамир спортоор хичээллэхийн ач холбогдлыг сурталчлах, мэдээлэл сурталчилгааны ажлыг нэгдмэл байдлаар зохион байгуулна	<p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж, сумуудад нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг зохион байгуулах зориулалт бүхий чийрэгжүүлэлтийн танхим, сургууль, цэцэрлэгийн тоглоомын талбай байгуулах, засварлах ажлыг төсвийн болон тогтвортой амьжиргаа төслийн хөрөнгөөр 8 суманд хэрэгжүүлсэн. Мөн Улаангом хотноо чийрэгжүүлэлтийн танхим 3 шинээр байгуулагдан ашиглалтанд орсон. Сар бүр зохион байгуулан явуулах өдөрлөг АСТ-ын зааврыг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргэж байна. Үүнд: Чандмань улаан ууланд цасны баяр, өдөрлөг, нийтийн явган аялал, кросс гүйлт зэрэг 21 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд түүнд давхардсан тоогоор 14500 орчим хүн хамрагдав. Мөн 7-64 насны нийт 39736 иргэнээс бие бялдрын сорил авч дүнг нэгтгэлээ. Судалгаанд хамрагдагсадын 9591 буюу 24.1 % А, 10915 буюу 27.5 % В, 11062 буюу 27,8 % С, 7702 буюу 19,4 % D, 466 буюу 18,2 % F үнэлгээтэй тус тус шалгагдсан судалгаа гарч байна. Улаангом хотноо үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон аж ахуйн нэгж 48 байгууллагыг БТСГ-ын дасгалжуулагч нарт хариуцуулан өгч биеийн тамир, спорт, дасгал хөдөлгөөнөөр хичээллэхийн ач холбогдол болон ажлын байран дахь эрүүл мэнд сэдэвт сургалт, мэдээллийг сар тутам байгууллагууд дээр зохион байгуулж байна.</p>	70
	3	Нийтийн биеийн тамир спортын байгууллагын барилга байгууламжийн засвар үйлчилгээ ашиглалтыг үе шаттай сайжруулна	<p>Шинээр ашиглалтанд орсон спортын ордон нь нийт 846 хүний суудалтай бөгөөд улсын аварга шалгаруулах болон Олон улсын чанартай спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулан явуулах боломжтой. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж сумуудад нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг зохион байгуулах зориулалт бүхий чийрэгжүүлэлтийн танхим,</p>	90

			сургууль, цэцэрлэгийн тоглоомын талбай байгуулах засварлах ажилд төсвийн болон тогтвортой амьжиргаа төслийг 8 суманд хэрэгжүүлсэн. Мөн Улаангом хотноо чийрэгжүүлэлтийн танхим 3 –ийг шинээр байгууллаа. / ХХҮХ, ахмадын хороо, фитнес клуб/ Спортын ордонд олон улс, улс, бүс аварга шалгаруулах шаардлага нөхцлийг хангаж электрон самбар байрлуулах, ширээний шагайн спорт хөгжүүлэх зорилгоор уралдаан тэмцээн зохион байгуулах бүрэн хэрэглэл, материалаар хангагдаад байна.	
1.1.20	3	Хяналт шинжилгээ, үнэлгээний нотолгоог ХДХВ/ДОХ/БЗДХ-ын эсрэг хариу арга хэмжээ төлөвлөх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана	ХДХВ/ДОХ/БЗДХ-ын хянах ажлын хэсгийг 2009 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 225 тоот захирамжаар батлан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. 2008, 2009, 2010 онуудад ХӨСҮТ, Глобаль сагнгийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төсөл, ЗГХЭГ-ын үндэсний салбар хорооны ажлын багтай хамтран хяналт үнэлгээг хийснээр тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлон сайн дурын зөвлөгөө шинжилгээний төвийг байгуулах шаардлагатай эм хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, олон нийт, зорилтот бүлгүүдэд сургалт явуулах, 2010-2012 онд ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх 3 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталж орон нутгийн төсвөөс 15 сая төгрөгийн санхүүжилтийг иргэдэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгаа, оношлуур, хамгаалах хэрэгсэлээр хангахаар тусгагдаад байна. Сайн дурын зөвлөгөө шинжилгээний төвөөр 478 хүн хандсанаас 343 хүнийг эмчилгээнд хамруулан ХДХВ –ийн халдварыг илрүүлэх шинжилгээ 116 хийгдсэн байна. ХДХВ/ДОХ/БЗДХ – ууд түүнээс урьдчилан сэргийлэх талаар 4 удаагийн сургалтыг 500 гаруй оролцогчдыг хамруулан ЗГХЭГ –ын ХДХВ/ДОХ-оос сэргийлэх ажлын алба, ХӨСҮТ хамтран зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.	50
1.2.2	1	Баг бүр гэр цэцэрлэг байгуулж хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжин, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ	НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Завханд 3, Зүүнхангайд 3, Тэсэд 3, Наранбулагт 3, Тариаланд 1, Хяргаст 1, Өндөрхангайд 2 , Дэлхийн банкны санхүүжилтийн “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” төслөөр Зүүнговьд 2, Давстад 2, Зүүнхангайд 2, Наранбулагт 2, Өлгийд 2, Өмнөговьд 1, Өндөрхангайд 2, Ховдод 2, Сагилд 2, Тэсэд 6, нийт 23 гэр цэцэрлэг, Дэлхийн зөн ОУБ-аас Өндөрхангайд 1, ТА-2 төслөөр Өмнөговьд 2, орон нутгийн нөөцөөр Давстад 1, Малчинд 3, Өлгийд 1, Түргэнд 1 гэр цэцэрлэг байгуулж, бүгд 48 нүүдлийн гэр цэцэрлэг ажиллаж байна. Х өдөөгийн 62 багаас 52 нь гэр цэцэрлэг болсноор гэр цэцэрлэгийн сургалтанд 1808 хүүхэд хамрагдаж байна. СӨБ-д 5725 хүүхэд суралцаж, хамран сургалт 82,9 хувьтай байна 2010 онд “Аривжих-Увс”ХХК өөрийн хөрөнгөөр Улаангом суманд цэцэрлэгийн барилга ашиглалтанд оруулж төрийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэллээ.	90
	2	Өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг олгоно	Хүүхдийн хоолны зардал 2009 оноос 1100 төгрөг болж өссөн. Аймгийн хэмжээнд т өрийн өмчийн 26 цэцэрлэгийн 3357 хүүхдэд хувьсах зардал олгож байна.	90

	4	Цэцэрлэгийн тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангаж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ	Аймгийн 26 цэцэрлэгийн 22-т нь тоглоом, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээд байна.	90
	5	Цэцэрлэгийн барилга барих өргөтгөх засварлах замаар хүчин чадлыг нэмэгдүүлнэ	Тариалан болон Улаангом сумын 1-р цэцэрлэгт өргөтгөл барьж ашиглалтанд орсноор ор хоног 125 – аар , Цагаанхайрхан, Наранбулаг, Түргэн, Улаангом сумуудад тус бүр 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг баригдаж 2009-2010 онд ашиглалтанд орж, цэцэрлэгийн хүчин чадал 525 ор хоногоор нэмэгдэж цэцэрлэгийн орны тоо 2505 боллоо. Малчин, Улаангом сумын 1,2,3,4,5-р цэцэрлэгийн барилгад их засварыг БСШУЯ-ны нийт хөрөнгө оруулалтаар хийлээ.	70
1.2.3	5	Бага боловсролын хамран сургалтыг 95 хувьд хүргэнэ	Бага боловсролын нас/6-11/-ны 10789 хүүхдээс 10286 хүүхэд сургуульд хамрагдаж байгаа ба хамрагдалтын хувь 95.3 байна.	100
1.2.4	5	Багшийн мэргэжлийн үнэлэмж нэр хүндийг дээшлүүлж багш боловсролын байгууллагын удирдах ажилтны цалин хангамжийг нэмэгдүүлнэ	2009, 2010 онд боловсролын хуулийн 43.1.4 дүгээр заалтын дагуу сургуулийн 49 багшид 205.5сая т өгрөг, цэцэрлэгийн 13 багш ажилтанд 76.3 т өгрөгийн тэтгэмж, мөн хуулийн 43.1.7 дахь заалтын дагуу сургуулийн 132 багшид 182сая т өгрөг, цэцэрлэгийн 7 багшид 9.7 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. 2008 оны 54-р тогтоолын дагуу 2010 онд үр дүнгийн урамшуулалд ер өнхий боловсролын сургуулийн давхардсан тоогоор 336 багш ажилтанд 634.1 сая төгрөг, цэцэрлэгийн 829 багш ажилтанд 163 төгрөгийн урамшуулалт цалин олгосон байна.	50
	6	Багш ажилтнууд сургууль дээрээ мэргэшил дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай орчны стандарт боловсруулж төрийн өмчийн бүх сургуулийн багш нарын өрөө, ажлын байрыг стандартын шаардлагын дагуу тоноглоно	Засгийн газрын 2008 оны 316-р тогтоолоор батлагдан гарсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор дэд хөтөлбөр болон, багш өөрийн мэдлэг боловсролоо ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллаад байна. Мөн БСШУ-ны сайдын 2008 оны 114-р тушаалаар батлагдан гарсан “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулах журмын дагуу аймгийн нийт 975 багшаас 620 багш ажлын байрандаа буюу сургуулийн түвшинд мэргэжлээ дээшлүүлж , 28 сургууль багш нарын тохижуулсан өрөөтэй ,4 сургууль багшийн хөгжлийн танхимийг байгуулан ажиллуулж байна	70
1.2.5	1	Хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшинг нэмэгдүүлнэ	“Бичигтэн болох “НҮБ-ын 10 жил”-ийн ажлын хүрээнд бичиг үсгийн боловсрол олгох талаар БСШУСайдтай БСГ-ын даргын байгуулсан гэрээний дагуу сумын Засаг дарга, сургуулийн захирал, албан бус боловсролын багш нартай гэрээ байгуулан зуны сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Бичиг үсгийн сургалтыг зохион байгуулахын тулд шинээр хэвлэгдэн гарсан “Билгийн нүд”, “Амьдралын их сургууль” сурах бичиг, гарын авлагыг төвөөс татан авч сургалтанд ашиглуулахаар гэгээрэл төвүүдэд хүргээд байна. Бичиг үсгийн сургалтанд ашиглах гарын авлага, ном, CD, кассетийг бүх сумын албан бус боловсролын багш нарт хүргүүлэн сургалтандаа ашиглаж эхлээд байна. Бичиг үсэг үл мэдэгч нийт 480 гаруй хүн байгаа ба үүнээс 350 хүнийг сургалтанд хамруулж, 200 хүнийг бичигтэн болгож дараа шатны сургалтанд сургаж байна.2010 оны эцэст 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалт 99.1% болж бичиг үсэгт тайлагдаагүй залуучууд 0.09%-ийг эзэлж байна.	90

	2	Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдад албан бус боловсрол дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгоно	Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрөөр 48 бүлэгт 1146 суралцагч суралцаж байгаагийн 452 нь бага боловсролд, 444 нь суурь боловсролд, 250 нь бүрэн дунд боловсролд хамрагдсан. Эдгээрээс энэ оны хичээлийн жилд сургуульд огт ороогүй 91, сургууль завсардсан 304 суралцагч шинээр элсэн суралцаж байна. 200 хүнийг бичиг үсэгтэн болгож, дараагийн түвшиний сургалтанд суралцах боллоо. Аймгийн хэмжээнд 19 гэгээрэл төв ажиллуулж сүүлийн 2 жилд 516 хүнд бага боловсрол , 426 хүнд суурь боловсрол ,301 хүнд бүрэн дунд боловсрол олгосон.	90
1.2.6	3	Төрөөс ерөнхий боловсролын сурагчдыг сурах бичгээр хангах график төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулна	Ерөнхий боловсролын төрийн болон хувийн сургуульд сургуулийн номын сангаар дамжуулан 2009-2010 оны хичээлийн жилд бүгд 20103 сурах бичгийг шинээр хэвлэн БСШУ-ны яамнаас батлан ирүүлсэн тоогоор “Адмон”, “Мөнхийн үсэг”, “Битресс”, “Соёмбо”, “Содпресс” хэвлэлийн газрын аймаг дахь борлуулагчаар дамжуулан сургууль бүрд хүргэсэн. 12 жилийн тогтолцооны 6 настай 1-р ангийн хувьд 6 төрлийн 12606 номыг төрийн болон өмчийн сургуулиудад хүргэсэн. 6 настай 1-р ангийн хувьд ихэнх сургуулиуд 100 хувь сурах бичгээр хангагдсан 2010-2011 оны хичээлийн жилд дахин хэвлэсэн сурах бичгүүдийг бүх сургуулиудад “Адмон”, “Мөнхийн үсэг”, “Битпресс”, “Соёмбо”, “Улаанбаатар хэвлэл”-ийн газрын гэрээт борлуулагчаар түгээсэн нийт сургуулийн хүүхдийн сурах бичгийн хангалт 75%-тай байна.	70
1.2.7	1	“Үдийн хоол хөтөлбөр” хэрэгжүүлэхтэй холбогдуулан сургуулийн хоолны газар, дотуур байрны гал тогоог зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна	Энэ зорилтын хүрээнд Тэс, Зүүнговь, Зүүнхангай,Өндөрхангай, Цагаанхайрхан, Өлгий, Наранбулаг, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн, Завхан, Тариалан, Давст, Сагилсум, Увс -Эрдэм сургуулиудын гал тогооны цахилгаан тоног төхөөрөмжийг шинэчилж нийт гал зуух бүхий сургуулийннь 53.5% шинэчлэгдлээ.	50
	2	“Үдийн хоол хөтөлбөр” –ийг хэрэгжүүлэх журам батлан мөрдүүлж сурагчдыг хөтөлбөрт ээлж дараатай хамруулна	Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Дэвшил бага сургууль, Давст, Зүүнхангай Ховд, Тэс сумдын ахлах сургуулиуд долоо хоногт 2 удаа сурагчдад халуун хоолоор үйлчилж байна.	30
1.2.9	1	Ерөнхий боловсролын сургуулийг 3 дугаар ээлжгүй болгоход чиглэсэн арга хэмжээ авна	Улаангом сумын Буянт хороололд 640 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилга энэ хичээлийн шинэ жилээр ашиглалтад орсноор Улаангом сумын 2 цогцолбор сургуулийн ачаалал багассан бөгөөд аймгийн хэмжээнд Ээлжээр хичээллэдэг сургууль байхгүй боллоо.	100

	3	Ангийн самбар, тавилга, сурагч, багшийн ширээ сандлыг ээлж дараатай шинэчилнэ	Ерөнхий боловсролын сургуулийг 12 жил тогтолцоонд шилжүүлэхтэй холбоотойгоор 2008-2009 хичээлийн жилд 6 настай хүүхдийн 516 үлэгт бүрэн ширээ сандал олгосон. 2009 онд “Тогтвортой амьжиргаа” төслийн хүрээнд ерөнхий боловсролын 12 сургуульд 110.9 сая төгрөгийн хатуу зөөлөн эдлэл болон, багш сурагчдын ширээ сандал шинэчилсэн байна. 2010 онд 8 сургуулийн 24 ангийн ширээ сандлыг шинэчилсэн.	70
	4	Дотуур байр барьж өргөтгөн, дотуур байрны орчин, ариун цэвэр, усны хангамжийг сайжруулна	2010-2011 оны хичээлийн жилд Баруунтуруун сумын ахлах сургуульд 50 хүүхдийн, Өлгий сумын ахлах сургуульд 80 хүүхдийн, Зүүнговь сумын ахлах сургуульд 100 хүүхдийн, Тэс, Өмнөговь сургуульд тус бүр 100 хүүхдийн ортой дотуур байр шинээр баригдаж, Бөхмөрөн, Тариалан, Завхан, Наранбулаг, Өндөрхангай сумын дотуур байрыг засварласнаар дотуур байрны багтаамж аймгийн хэмжээнд нийт 490 ороор нэмэгдлээ. 24 дотуур байрны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Хяргас, Сагил, Өмнөговь сумын сургуулийн дотуур байрууд эрүүл ахуйн орчны хувьд үлгэр жишээ, Өлгий, Наранбулаг, Завхан, Цагаанхайрхан сумын сургуулийн дотуур байрууд хангалттай түвшний эрүүл ахуйн орчныг бүрдүүлсэн байна. Улсын мэргэжлийн хяналтын газрын шалгалтаар Шинэ-Ирээдүй, Эрдэм-Оргил цогцолбор, Чандмань Эрдэм ахлах сургуулийн дотуур байруудын орчин, ариун цэвэр сайн гэж үнэлэгдсэн. Сагил, Өмнөговь, Тариалан, Зүүнговь, Тэс сумдын болон Шинэ -Ирээдүй, Эрдэм-Оргил цогцолбор сургуулийн дотуур байрууд шинээр цэвэр, бохир усны шугам сүлжээтэй болж, Өлгий, Өмнөговь, Тариалан сумын дотуур байранд шинээр худаг гаргаж, усны хангамжаа сайжруулсан. Нийт 33 дотуур байрнаас 6 нь бохир цэвэр усны системд холбогдсон байна.	70
1.2.10	1	Зарим аймгийн төвд усан бассейн байгуулж хүүхэд залуучуудын биеийн тамир спортоор хичээллэх орчин бүрдүүлнэ	Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний биеийн тамир спортоор хичээллэх таатай орчин бүрдүүлэх зорилгоор 846 суудал бүхий спортын ордон барьж ашиглалтанд оруулж, хүүхэд залуучуудын парк барьж байна.	30
1.2.12	2	Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг сайжруулж эрэлт нийлүүлтэд тохирсон мэргэжилтэй ажилтан бэлтгэх төлөвлөлтийг сайжруулна	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тоон судалгааг Аймгийн ЗДТГ-ын НХХ, СТХ, ХХҮХ, Улаангом коллеж, Баруун бүсийн сургалт арга зүйн төв хамтран 15 суманд явуулж, дүнг үндэслэн Улаангом коллежид мэргэжилтэй ажилтан бэлтгэх 2010-2012 оны төлөвлөлтийг хийж Удирдах зөвлөлийн хурлаар баталсан. Энэ ажилд нийт сумдын 78.9% нь хамрагдлаа.	70
1.2.14	3	Дотоодын их дээд сургуульд суралцахаар зохих журмын дагуу элсэж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын захиалгаар албан ёсны гэрээ байгуулсан оюутны сургалтын зардлыг төрөөс хариуцна	Малчин сумаас 6, Наранбулаг сумаас 2, Ховд сумаас 1, Сагил сумаас 1 нийт 10 оюутан эмч, багш, инженерийн мэргэжлээр тухайн сумынхаа засаг даргатай гэрээ байгуулан суралцаж байна.	50

1.2.20	1	Бүсийн төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа дээд болон мэргэжлийн сургалтын байгууллагыг төрөөс дэмжинэ	Баруун бүсийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болох Улаангом коллеж ажиллаж байгаа бөгөөд хичээлийн байрны өргөтгөл 730 сая төгрөгөөр барьж эхэллээ. Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, хувьсах зардлыг оновчтой тооцож олгох байдлаар төрөөс дэмжиж байна. Улаангом коллеж нь 2010оон эхлэн барилга, агро техник, нийтийн хоол үйлдвэрлэл гэсэн 3 мэргэжлээр дипломын боловсролтой техникийн ажилтан, 23 мэргэжлээр мэргэжилтэй ажилчин, барилгын өрөгч, гагнуурчин, замын барилгын техникч, эрчимжсэн фермерийн аж ахуй гэсэн 4 мэргэжлээр Оюу толгойн мэргэжилтэй ажилчид бэлтгэх, Монголын Мянганы сорилтын сангийн өрсөлдөөнт тэтгэлэгт хөтөлбөрөөр иргэдэд газар тариалангийн эрхлэх сургалт явуулах сургалтын статустай политехникийн коллеж болон ажиллаж байна.	70
1.2.25	1	Соёлын төвүүдийн барилгыг шинээр барих, их засвар хийх ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ	Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт Өндөрхангай, Өлгий, Баруунтуруун сумын соёлын төвийн барилгыг дуусгаж, сумдын соёлын төвийн хөгжим техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, Наранбулаг, Сагил, Давст, Түргэн, Тариалан сумын соёлын төвүүдэд их засвар хийж, 2009 онд Өлгий, Баруунтуруун сумдын соёлын төвийн барилгыг ашиглалтанд өгч соёлын төвүүдэд БСШУЯ-аас шинэ сандал ширээ олгосон байна. Мөн Түргэн, Давст сумын соёлын төвийн барилгын их засварын ажил дуусгаж 2010 онд Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар Өндөрхангай сумын соёлын төвийн барилгад нийт 325 сая₮ шийдвэрлэгдэж энэ оны 7 сард хүлээлгэн өгсөн байна. Соёлын төвийн дотоод хөрөнгө оруулалтын хүрээнд Тогтвортой амьжиргаа- 2 төслийн санхүүжилтээр Наранбулаг, Давст, Малчин, Өлгий, Өмнөговь, Тариалан, Тэс, Ховд сумдын соёлын төвийн дотоод тохижилт сандал, ширээ, техник паратур, музейн үзмэрийг сэргээн засварлах, тайзны гэрэлтүүлэг, видео проектор зэрэгт нийт 36 сая гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт нийлүүлсэн байна. Ер нь аймгийн хэмжээний төрөөс санхүүждэг соёл, урлагийн байгууллагуудад их засвар болон шинэ барилга байгууламж барьж соёл, урлагийн байгууллагын ажиллах орчин, материаллаг баазыг сайжруулах үйл ажиллагаа шаардлагын түвшинд хүрч байна.	70
	3	Хөдөө орон нутгийн алслагдсан хүн амыг мэдээллээр хангах хүрээ хүртээмжийг нэмэгдүүлж “Явуулын номын сан”-гийн үйлчилгээг нэвтрүүлнэ	Хөдөөгийн 18 сумын 67 багт нийтдээ 50 гаруй мянган хүнд соёл, урлагийн үйлчилгээ хүрч үйлчилжээ. Сумдын багийн Засаг дарга нар соёлын төвийн номын сангийн эрхлэгчтэй хамтран “Аяны богц” явуулын номын санг ажиллуулж эхлэсэн. Өнөөдрийн байдлаар нийт 15 сум явуулын номын сан буюу аяны богц нэртэй үйл ажиллагааг жилд 2-3 удаа хүргэж ажиллаж байна. Бөхмөрөн, Сагил сумын номын сангийн эрхлэгч нар багийн Засаг дарга нартай гэрээ байгуулан байнгын дэвтэр хөтлөн захиалга өгч номын солилцоо хийн ажиллаж байна. Аймгийн төв номын сан, сумдын соёлын төвтэй байнгын хамтын ажиллагаатай байж номын солилцоо, фондын баяжилт хийх зэрэг ажлыг судалгаанд тулгуурлан захиалга өгч хамтран ажиллаж байна. Аймгийн номын сангийн веб хаягийг шинээр нээснээр сум орон нутгийн болон аймгийн төвийн бусад байгууллагууд төв номын сангийн мэдээ мэдээллийг хурдан шуурхай хялбар замаар авах нөхцлийг бүрдүүлж эхлээд байна.	70

			<p>Цаашдаа хөдөө орон нутгийн алслагдсан хүн амыг мэдээллээр хангах хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор номын сангийн үйлчилгээг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцүүлэн олон хэлбэрээр төрөлжүүлэн хүргэж байгаа. Зарим сумдын соёлын төвөөс багийн Засаг дарга нартай гэрээ хийж нүүдлийн номын сан ажиллуулснаар хөдөөгийн уншигчдын тоо нэмэгдэж байна.</p>	
1.2.28	3	<p>Үндэсний түүх, нүүдлийн соёлоо судлан сурталчлах, монгол бичгээ өвлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, “Монгол бичиг”, “Морин хуур, уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монгол бии биелэгээ”, “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-үүдийг үргэлжлэн хэрэгжүүлнэ</p>	<p>Утга соёлын өвийг өвлөн тээгчийн судалгааг 18 сумын хэмжээнд гаргаж БСШУ-ны яамны Соёл урлагийн газарт 109 хүний судалгааг хүргүүлсэн.</p> <p>Энэ хичээлийн жилээс эхлэн Шинэ Ирээдүй цогцолбор сургуулийн үндэсний сургагч багш П.Лхагва орон нутгийн “САМА” телевизээр монгол бичгийн хичээлийг 7 хоногт 1 удаа тогтмол зааж байна.</p> <p>Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд сум, сургуульдаа дэд хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд ажлын төлөвлөгөө гарган, жил бүрийн 5-р сарын 20, 10 сарын 20-ны дотор зохион байгуулсан ажлынхаа тайланг БСГ-т ирүүлж хэвшлээ.</p> <p>Морин хуур, уртын дуу үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд нийт 141 морин хуурч, 169 уртын дууч бүртгэгдсэн байна. Морин хуурын сургалтанд 125, уртын дууны сургалтанд 124 хүүхэд, насанд хүрэгчид сурч байна.</p> <p>Алдарт морин хуурч Г.Жамъяаны нэрэмжит Олон улсын мэргэжлийн морин хуурчдын III уралдаанд 3 уран бүтээлч оролцлоо.</p> <p>Морин хуур, Уртын дуу, Монгол хөөмий зэрэг үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зорилготой аймгийн Хөгжимт драмын театрын дэргэд дугуйлан хичээллүүлж байна.</p> <p>Монгол Хөөмий үндэсний хөтөлбөрийн хүрээнд Аймгийн төв, 6 сумын нийт 32 хөөмийчид бүртгэгдсэн. 37-н хүүхэд, насанд хүрэгчид хөөмийн сургалтанд сурч байна. 2010 онд хөөмийч МУГЖ Э.Тойвоогоор багшлуулан 18 сумдаас шавь шалгаруулан сургаж байна.</p> <p>Бий биелэгээ үндэсний хөтөлбөрийн хүрээнд язгуур урлагийн наадамд олон бийчид амжилттай оролцлоо. Язгуур урлагийн наадмаар оролцсон бийчдийн судалгааг төгс гаргасан ба Утга соёлын өвийн төвд хүргүүлэхээр бэлэн болоод байна</p> <p>Соёлын өвийн Бүртгэл-Мэдээллийн сан бүрдүүлэн ажилласнаар бүх сумдын үл хөдлөх дурсгалын видео бичлэг, гар тэмдэглэл, ардын урлагийн наадмын аудио болон видео бичлэг, аймгийн музейн видео бичлэг бүхий танилцуулга, видео архив тус тус төвлөрч үндсэн фонд сан хөмрөгийн баялаг судалгааг бий болгоод байна. Сум бүр өөрийн нутаг дэсгэрт бүртгэгдсэн түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг шинээр бүртгэн авах, хамгаалалтанд авч сэргээн засварлах, тэмдэгжүүлэх,сэргээх, хашаа хайс барьж тодорхой эзэнтэй болгох ажлууд хийгдээд байна.</p> <p>Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөрүүдийн хүрээнд эхний ээлжинд 7-8 суманд түүх соёлын дурсгалт газрыг тухайн нутаг дэвсгэрийн малчдад гэрээгээр хариуцуулж эзэнжүүлэх ажлыг хийж байна. Мөн түүх соёлын дурсгалт газрыг сэргээн засварлах, хашаа хайс барьж хамгаалах орчин тойронд цэвэрлэгээ хийх ажлыг тогтмол зохион байгуулж байна.</p> <p>Мөн Харлаг Бэйсийн сүм”-ийн гадна дотно орчны цэвэрлэгээ хийж, хаалга цонхыг засаж, уг сүмийн</p>	90

			<p>барилгыг хамгаалах зорилгоор манаач буулган зохих түвшинд хамгаалалтын арга хэмжээ аван ажиллаж байна.</p> <p>2010 онд аймгийн Засаг даргын 36 дугаар захирамжийн дагуу язгуур урлагийн наадмыг 3 үе шаттай , 1500.0 мянган төгрөгний санхүүжилттэйгээр зохион байгуулан нийт 14 төрлөөр, 19 сумын 300 гаруй ардын авьяастан нар оролцлоо.</p> <p>Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу Улаанбаатарт соёлын өдрүүдийг зохион байгуулах ажлын хүрээнд Увсын цэнхэр хязгаар нэртэй уран бүтээлийн тайлан тоглолт тавьсан. Аймаг орон нутгийнхаа ардын урлагийг сэргээн сурталчлах суралцах зорилгыг өвөрлөн 11 сард Улаанбаатар хотноо Их хөгсүү ТББ-аас язгуур урлагийн наадмыг зохион байгуулсан. Аймгийн Ойрад ХЖТ-ын ерөнхий найруулагчаар ахлуулсан 54 ардын авьяастан, уран бүтээлчид 11 төрөлд амжилттай оролцов. 2010 оны 06 сард аймгийн ЗД-ын 304 дүгээр захирамжийн дагуу сан хөмрөгийн нэгдсэн тооллого явагдаж дууссан.</p> <p>Аймгийн музейгээс үндэстэн ястны онцлог шинж чанарыг хадгалсан эд өлгийн зүйлсийг тус бүрээр нь ангилан бүртгээд төрөлжүүлсэн.</p>	
1.3.1	2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачлагад тулгуурлан орон нутаг бүсийн хөгжил, салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачлагад тулгуурлан орон нутаг бүсийн хөгжил, салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт албан бус салбарт ажиллагсдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байр бий болгох, зээлийн үйлчилгээнд хамруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар жилдээ 1000-1200 ажлын байр бий болгох асуудлыг тусган хэрэгжүүлж 1402 иргэнийг байнгын ажлын байранд зуучлаад байна. 2097 хүнийг мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрууллаа.</p>	90
1.3.6	2	“нэг өрх- нэгээс доошгүй ажлын байр” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ	<p>Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд болон аймгийн Засаг даргын хооронд байгуулсан 2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний 1.2-ын 8 дахь хэсэгт “Нэг өрх - нэгээс доошгүй ажлын байр” хөтөлбөрт 8 өрх хамруулахаар тусгасны дагуу 8 өрхийн 8 гишүүнийг ажлын байртай болголоо. Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүд 1695 байгаа ба 1400 гаруй хүнийг ажлын байранд зуучлаад байна.</p>	30
1.3.7	1	Эрэлтэд тулгуурласан “Эрхийн бичиг”-ийн сургалтыг орон нутагт өргөжүүлнэ	<p>“Эрхийн бичиг”-ийн сургалтыг орон нутагт өргөжүүлэх ажлууд хийгдэж байна. 2009 онд мэргэжил олгох, ур чадвар эзэмшүүлэх эрхийн сургаланд 605 хүн, аж ахуй эрхлэх, төсөл хөтөлбөр боловсруулах сургалтанд 200 хүнийг тус тус хамруулж сургалтын зардалд ХЭД сангаас 68.9 сая төгрөг зарцууллаа. Улаангом коллежоос санаачлан 15 суманд судалгааны баг ажиллаж ажилгүй иргэдээс суралцах мэргэжил, ажиллах салбарын эрэлтийн талаар дэлгэрэнгүй судалгаа авч нэгтгэх ажлууд хийлээ.</p> <p>2010 онд төндэрт ялсан 17 сургалтын байгууллагатай гэрээ байгуулж, эрхийн бичгийн мэргэжил олгох болон давтан сургалтанд 739 ажилгүй иргэдийг хамруулж 64,6 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцууллаа.</p>	90

1.3.15	1	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон техникийн боловсролын сургуульд суралцагчдын тоог 3 дахин нэмэгдүүлнэ	2010-2011 оны хичээлийн жилд 21 мэргэжлээр 1758 сурагч суралцаж байна. Суралцагчдын тоо 2009 онтой харьцуулбал 1.2 дахин нэмэгдлээ.	50
1.4.1	1	Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, тэдний ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авна	Мэргэшсэн нийгмийн ажилтнуудаар нийгмийн ажлыг гүйцэтгүүлж жилд 2 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөөг холбогдох газруудтай хамтран өгч ажиллаж байна. 19 суманд мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг томилон ажиллуулж, мэргэшүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж, ажиллах нөхцөл боломжоор хангаж, компьютер, принтер бусад техник хэрэгсэлтэй болголоо. Ажиллагсдын 80 хувь нь төрийн албаны мэргэжлийн шалгалтанд тэнцэж, төрийн захиргааны жинхэнэ албан хаагчид болоод байна. Тэдний хуульчлагдсан ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавин ажиллаж байна.	90
1.4.6	1	Нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж буй төв болон орон нутгийн байгууллагуудын ажил үүргийн зохион байгуулалтыг сайжруулж нийгмийн хамгаалалын үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээ авна	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 63-р заалтад Нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд чиглэсэн халамж үйлчилгээг сайжруулах асуудлыг тусган хэрэгжүүлж нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд хүргэж буй ХХҮХ, сумдын ЗДТГ-ын нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилдаа тусган ажиллаж байна. 2010 онд халамжийн сангаас 4069 ахмад настанд 242.5 сая, хөгжлийн бэрхшээлтэй 1185 иргэнд 112.3 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж үзүүллээ. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асарч байгаа 1317 хүнд 116.2 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг олголоо. Хүний хөгжил сангаас хишиг хувь хүртээх үйлчилгээнд давхардсан тоогоор 183.0 мянган хүнд 7,6 тэрбум төгрөг зарцуулаад байна. Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд 805 хүнд 90,1 сая төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүллээ. Нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай болгоход анхаарч сумын амьжиргаа дэмжих зөвлөлийг дэмжин ажиллаж байна.	90
1.4.11	2	“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” т үндэслэн бүс нутгийн болон эдийн засаг, дэд бүтцийн хөгжилтэй уялдсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр одоогоор батлагдаж ирээгүй боловсруулалтын шатанд байгаа	10
1.4.12	1	Хувийн хэвшил, иргэдийн оролцоо, санаачлагад тулгуурлан “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ	Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр одоогоор батлагдаж ирээгүй байна. Өрхийн хөгжлийн хөтөлбөрийг Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөрийн Өрхийг чадваржуулах стратегитэй уялдуулах ажлын хэсэг үндэсний хэмжээнд ажиллаж байгаа ба аймагт Тариалан сумын нэн ядуу 80 өрхийн гишүүдийг өрхийн сургалт үнэлгээнд хамруулж чадваржууллаа.	10
	2	“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т хамрагдах өрхийг сонгох, өрхийн хөгжлийн төлөвлөгөө гаргах аргачлалыг боловсруулна	Ядуу 560 өрхийн дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн ХХҮГ-т хүргүүлж, сонгогдсон 384 өрхийн хөгжлийн төлөвлөгөөг өрхийн гишүүд, сумын нийгмийн ажилтантай хамтран боловсруулаад байна.Энэ онд 90 өрхийг ядуурлаас гаргах зорилт дэвшүүлэн ажиллаж, эдгээр өрхийн гишүүдээс аж ахуй эрхлэх сургалтанд 32, мэргэжил олгох сургалтанд 36	70

			иргэнийг хамруулж, байнгын ажлын байранд 19 иргэнийг зуучилж, 54 иргэнийг түр ажлын байраар хангаж, шинэ ажлын байр бий болгох зээлд 46 өрхөд 23 сая төгрөгийн санхүүжилт олгож амьжиргааг нь тодорхой хэмжээгээр дээшлүүллээ. ХХҮХ-ээс сумын нийгмийн ажилтнуудад хийсэн 4 удаагийн сургалтын үеэр өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, нэн ядуу өрхийн гишүүдтэй хэрхэн харьцах, өрхийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд ямар ямар арга хэмжээ зохион байгуулж болох талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сумын нийгмийн ажилтнууд ХХҮГ-аас ирүүлсэн шинэчилсэн загварын дагуу өрхийн гишүүдтэй хамтран өрхийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх ажлыг хийлээ.	
	3	Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн тухайн өрхийг хөгжүүлэх, амьжиргааг дээшлүүлэх ажлыг хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотойгоор зохион байгуулж хөтөлбөрт хамрагдсан өрхийн мэдээллийн сан байгуулна	Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг үндэслэн тухайн өрхийн хөдөлмөрийн насны хүн амыг мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамруулж, мэргэжил олгох, ажлын байртай болгох асуудлыг дэс дараатай авч хэрэгжүүлж, хамрагдсан өрхийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг хийж эхлээд байг хэмжээнд 560 өрхийн мэдээллийн сантай боллоо.	30
	4	Нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн ядууралтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ	Сумдын ажилтнууд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх төрөл бүрийн сургалтууд зохион байгуулагдаж байна. Халамжийн үйлчилгээний ижил төрөлд хамрагдах өрх, иргэдийг өөрсдийнх нь санаачлагыг түшиглэн бүлгийн зохион байгуулалтанд оруулах, хамт олны бүлэг бүрдүүлэх, сургалтанд хамруулах, хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор ядуурлаас гаргах боломжийг судалж зарим төрлийн үйлчилгээг хэрэгжүүлж эхлээд байна. Ядуурлаас гаргахаар төлөвлөсөн 384 өрхөөс 2009 онд 17 сумын 59 өрхийн 118 иргэнийг өөрсдийнх нь санал санаачлагаар бүлгийн зохион байгуулалтанд оруулан 32 бүлгийн 32 төслийг нийгмийн халамжийн үйлчилгээний нэг төрөл болох олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлаас нийт 20 сая төгрөгөөр санхүүжүүлээд байна. Энэ онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 19 сумын 78 өрхийн 29 зохион байгуулалттай бүлэгт 18,6 сая төгрөгийн санхүүжилт олголоо.	50
1.4.15	1	“Хүн байхын учир аян”-ыг өргөжүүлж хүүхэд өсвөр үеийнхний “Гэр бүлдээ үүнийг хүснэ”, “Миний паспорт”, “Миний нэрийн хуудас” зэрэг хөдөлгөөн үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжинэ	Хүүхэд өсвөр үеийнхний нийгмийн амьдралд оролцох, хөгжих, мэдээ мэдээлэл хүртэх идэвхийг өрнүүлэхийн зэрэгцээ үе тэнгийнхэндээ туслах арга ухаанд суралцуулах, хамтран хөгжих, нийгэмд тустай олон сайн үйлсийн 2 сарын аяныг 2-р сарын 15-наас 4-р сарын 15-ны хооронд зарлан явуулж, 18 сургуулийн 12562 хүүхэд, өсвөр үеийнхэн хамрагдаж, нийгэм хамт олонд чиглэсэн 141 ажил хийсэн. Тариалан, Наранбулаг, Өндөрхангай, Бөхмөрөн сумдын сургуулиуд болон Эрдэм-оргил цогцолбор сургуулийн бага сургууль бусдаас илүү амжилт гарган оролцож Хүүхдийн төлөө хэлтсийн нэрэмжит алт, мөнгөн медаль өргөмжлөлүүдээр шагнагдсан. Хүн байхын учир аяны хүрээнд “Надад хэлэх үг байна” хэлэлцүүлэг, “Халамж” арга хэмжээ зохион байгуулж 4 удаагийн үйл ажиллагаанд 120 хүүхэд хамруулж, сургууль завсардсан 6 хүүхдийг албан бус боловсролд хамрууллаа. Хүүхэд, өсвөр үеийнхний дунд “Би гэр бүлдээ	70

			<p>үүнийг л хүснэ” гар зургийн уралдаан зарлан явуулж ерөнхий боловсролын 4 сургуулийн 41 хүүхдэд бүтээлээ ирүүллээ.</p> <p>Хүн байхын учир аяныг үргэлжлүүлэн зохион байгуулж гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, тэдний эцэг эхэд зориулсан 2 удаагийн сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн албатай хамтран зохион байгууллаа. Хүүхдийн мини парламентын загварыг турших “Миний паспорт” аяныг удирдамжийн дагуу зохион байгуулж дүгнэн урамшуулах Хүүхэд багачууд Монгол Улсдаа болон үе тэнгийн найз нөхөд, өөрийн амьдарч, суралцаж буй орчин мөн өөртөө зориулан их үйлсийг бүтээх нийгмийн амьдралд оролцох зорилгоор 2010 оны 01 сарын 20 -ноос 05 сарын 15-ныг хүртэл Миний паспорт аяныг зарлаж удирдамжийг сум сургуулиудад хүргүүлж тайлан авлаа. Ингэснээр хүүхэд ба насанд хүрэгчид хамтран тодорхой үр дүнтэй үйл ажиллагаанууд зохион байгуулан хэвших ба эдгээр хамт олон нь өгөдсөн аргачлалын дагуу олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулан орон нутгийн болон сургуулийн удирдлагууд, багш нараараа хянуулан баталгаажуулж, тэднээр өөрсдийн хамт олны паспорт дээр виза тэмдэглэл хийлгэн тайлангаа ирүүллээ. Үүнд нийт 6 сургуулийн 7 хамт олон тайлангаа ирүүлснээс Миний паспорт аяны Алтан өргөмжлөлөөр ЭОЦС –ийн Скаутын бүлгэм, Мөнгөн өргөмжлөлөөр Сагил сум, Хүрэл өргөмжлөлөөр Тэс сумын 1 тус тус шалгарч шагнагдав. Энэ үйл ажиллагаанд нийт 460 гаруй хүүхэд багачууд хамрагдав.</p>	
2	Хүүхэд амралт, чөлөөт цагаа өнгөрөөж мэдээлэл авч байгаа байдалд судалгаа хийж, хүүхэд өсвөр үеийг хариуцлагатай, бүтээлч, тусч энэрэнгүй, нийгмийн идэвхтэй иргэн болгож төлөвшүүлэх талаар эцэг эх, гэр бүлийн гишүүдийн мэдлэг хандлагыг өөрчилөх сургалт сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр ТББ-уудтай хамтран ажиллана	<p>Хүүхэд амралт чөлөөт цагаа өнгөрөөж мэдээлэл авч байгаа байдалд судалгаа хийсний дүнд РС, цахим тоглоомын газруудын мөрдөх журам боловсруулан гаргаж, тоглоомын газар ажиллуулж байгаа иргэдэд сургалт зохион байгуулсан. Мөн судалгааг үндэслэн хүүхдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд 2 төрлийн дугуйлан 2 ээлжээр хичээллүүлж 23 хүүхдийг үнэ төлбөргүй хамруулав.</p> <p>Хүүхдийг хариуцлагатай, тусч энэрэнгүй, нийгмийн идэвхитэй иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор аймгийн УЗХороотой хамтран Улаанзагалмайч 100 хүүхдийн туршлага солилцох үүлзалтыг зохион байгууллаа</p> <p>Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд чимэглэх урлаг, бүжиг, шатрын гэсэн 3 төрлийн дугуйланг 2 ээлжээр хичээллүүлэн 165 хүүхэд хамруулаад байна. Ерөнхий боловсролын сургуулиуд болон сумдын соёлын төвүүдэд урлаг, спортын дугуйлан секцэд 2000 гаруй хүүхэд, багачууд хамрагдан суралцаж байна. Хүүхдийн Хархираа зуслангийн ажилтнуудад зориулсан гарын авлага, стандарт, зөвлөмжүүдийг бэлтгэж хүүхдийн зуслангийн захиргаанд хүргүүлэв. Хүүхдийн зусланд Тува улсын 30, Монголын 170 хүүхэд амарсан бөгөөд хүнд нөхцөлд амьдарч байгаа болон тэргүүний 15 хүүхдийг аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр үнэ төлбөргүй амруулсан.</p> <p>Бөхмөрөн, Завхан, Баруунтуруун, Улаангом сумдын 240 эцэг, эхэд гэр бүлийн гишүүдийн мэдлэг хандлагыг өөрчлөх, хүүхдийг нийгэмшүүлэх, төлөвшүүлэх 9 удаагийн сургалтыг аймгийн Цагдаагийн газар, Прокурор, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Ардчилсан социалист эмэгтэйчүүдийн холбоо,</p>	70	

			Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо, Сайн тус төвтэй хамтран зохион байгууллаа.	
3		Хүүхэд өсвөр үеийнхний дунд эрүүл амьдралын дадал хэвшүүлэх, зохистой хооллолтыг эрхэмлэх, хорт зуршлаас татгалзах, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх талаар сургалт сурталчилгааг өргөжүүлнэ	<p>Хүүхдэд эрүүл амьдралын дадал хэвшил олгох сургалтын чанарыг сайжруулах зорилгоор аймгийн Улаан загалмайн хороо, Эрүүл мэндийн газартай хамтран эрүүл мэндийн хичээл заагч 35 багш, ангийн дарга 48 хүүхдийн 2 өдрийн “Цэвэр орчин” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран хүүхэд, өсвөр үеийнхэнд архи тамхины хор уршгийн талаар мэдлэг олгох сурталчилгааны ажлыг “Архи тамхигүй орчин бидний ирээдүй” сэдэвт аян явуулж, хүүхэд багачууд, албан байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүлийн дунд олон хэлбэрийн ажил зохион байгууллаа.</p> <p>Энэ арга хэмжээнд 20 бүлгийн 650 гаруй хүүхэд багачууд оролцож, аймгийн төвийн 5 багийн иргэд, хүүхэд багачуудын дунд “АСК” уралдаант тэмцээн зохион байгуулав. “Архи, тамхигүй орчин” нэртэй мэдээллийн самбарыг шинээр ажиллууллаа.</p> <p>Хүүхдийн өөрийн удирдлагын 7 байгууллагын шилдэг 45 хүүхдийн “Хүүхдийн оролцоо-хамтын ажиллагаа” сургалтын үеэр Эрүүл мэндийн газрын халдварт бус өвчин хариуцсан мэргэжилтнийг оролцуулан эрүүл ахуйн зөв дадал хэвшлийн талаар хичээл заалгаж, олж авсан мэдлэгээ чадвар болгож хэвшүүлэх талаар зөвлөгөө өгөв.</p> <p>Хүний томуугийн А/Н1Н1/ вируст цар тахал гарсантай холбогдуулан гараа тогтмол зөв угаах, зөв хооллох, эрүүл ахуйн дэглэм сахих талаар болон цартахлын үед гэрийн нөхцөлд авах арга хэмжээ, асаргаа сувилгаа, цартахлаас урьдчилан сэргийлэх талаар сурталчилгааг өрнүүлж бүх сумдад 2 удаа сурталчилгааны материал хүргүүлж, орон нутгийн МВС телевизээр 9 шторкыг өдөрт 3 удаагийн давтамжтай 27 хоног нэвтрүүлж, 120 цагийн сурталчилгааны реклам явуулсан.</p> <p>Улаангом сумын 3 сургуулийн 8-р ангийн сурагчдын дунд “Архи тамхигүй орчин бидний ирээдүй” сарын аяныг 4-р сарын 5 наас 4-р сарын 25-ныг хүртэл амжилттай зохион байгууллаа. Тус Аяны хугацаанд хүүхэд багачууд албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, гэр бүлийн дунд олон төрлийн ажлуудыг зохион байгуулсан тайлангаа ирүүлсэн ба аянд нийт 20 бүлгийн 650 гаруй хүүхэд багачууд оролцсон ба АСК тэмцээнийг сургуулиуд дээр зохион байгуулсан ба тэмцээнээс шалгарсан нийт 5 багийн эцсийн шалгаруулалтыг ХТХэлтэс дээр явуулаж шалгаруулав. Тус тэмцээнд ШИЦС –ийн “Хар цагаан”, “Цэнхэр дэлхий”, ЭОЦС –ийн “АТОБИ”, “МАСК”, ЧЭАС-ийн “ОД” багууд оролцсоноос ШИЦС –ийн “Цэнхэр дэлхий” баг I байр, ЭОЦС-ийн МАСК” баг II байр, ШИЦС –ийн “Хар цагаан” баг III байр тус тус эзэллээ.</p>	70
1.5.2	2	“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийг зарлана	Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил зарласан шийдвэр ирээгүй байна.	0
1.5.6	3	Ахмадууд нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, тэдний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлэх, чанартай насжилтыг дэмжих зорилгоор аймаг дүүрэг бүрд орон нутгийн нөөц хөрөнгө, бололцоог	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт ахмадын сувиллын байр барьж, ХХҮХ-ийн ахмадын сувиллын амралтын орны тоог өргөжүүлэх асуудлыг тусган хэрэгжүүлж ахмадын сувиллыг Хархираа амралтанд дулааны улиралд 2 гэртэйгээр тогтмол ажиллуулж, ахмадын сувиллын барилгын асуудлыг шийдвэрлэхээр холбогдох газруудад хандаад байна.	30

		ашиглан ахмадын ордон байгуулж ашиглалтанд оруулна	Ахмадын хороо дэмжиж 8 ажлын өрөө бүхий албан контортой болгож, 13,1 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг төсөвт суулган дэмжин ажиллаж, ахмадуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлэх зорилгоор Мерси Кор Монголд олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр чийрэгжүүлэлтийн өрөө тохижуулж ашиглалтанд орууллаа. Ахмад настны эрүүл мэнд, нөхөн сэргээх эмчилгээнд зориулж аймгийн Ахмадын хороонд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний зардлаас 2,0 сая төгрөгийг буцалтгүй хэлбэрээр олголоо. Энэ зардлаас чийрэгжүүлэлтийн кабинетыг тогтмол ажиллагаатай болгож, мэргэжлийн эмч ажиллуулж байна. Ахмад настны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний хөдөлгөөний идэвхийг өрнүүлэх, эрүүл насжилтыг дэмжих зорилгоор үдэшлэг уулзалтыг 14 хоногт 1 удаа зохион байгуулах удирдамж график гарган аймгийн Засаг даргын 2010 оны 10 сарын 14-ний өдрийн А/202 тоот захирамж гаргуулан бүх агентлаг, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүллээ. Ахмад настны эрүүл урт насралтыг дэмжих, насжилт судлалыг эрчимжүүлэх зорилгоор нэгдсэн эмнэлэгт насжилт судлалын кабинет ажиллуулж, эмч нарыг сургалтанд хамруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
1.5.10	1	Хүүхэд тэдний өөрийн удирдлагын байгууллага, хөдөлгөөн, хүүхдийн нэгдсэн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан тэдний санал хүсэлтийг шийдвэртээ тусгаж ажиллах талаар нутгийн захиргааны байгууллагыг зөвлөмжөөр хангаж ажиллана	Сумын Засаг дарга хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн нарт хүүхдийн оролцооны талаар хүүхдийн үүсгэл санаачилгыг дэмжих хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудыг арга зүйгээр ханган гишүүнчлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Дани-Монголын скаутын багтай хамтран төвийн 3 сургуулийн нийгмийн ажилтан, идэвхитэн сурагчдын дунд "ХӨУБ-уудын үйл ажиллагааг хэрхэн өргөжүүлэх нь сэдэвт 3 өдрийн сургалтыг явуулав. Хүүхдийн оролцоо өнөөгийн байдал, суманд хүүхдийн зөвлөлийг хэрхэн ажиллуулах сэдэвт бүсчилсэн сургалтанд 18 сумын нийгмийн ажилтнууд, хүүхдийн зөвлөлийн ахлагч, хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудыг чиглүүлэн ажилладаг багш нар 95 хүн хамрагдлаа. Аймгийн хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудын хүүхдүүдийг хамруулсан форумыг хүүхдийн зусланд зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах үүднээс "Монголын хүүхдүүд" үндэсний чуулганд хөгжлийн бэрхшээлтэй ЭОЦС-ын сурагч Б.Гүнжүүг явуулж, шийдвэр гаргах түвшинд дуу хоолойг нь хүргүүлсэнээр чуулганы шийдвэрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хангах санал тусгагдсан. 2010 оны 8 сарын 25-28 хооронд Баруун бүсийн хүүхдийн чуулган, язгуур урлагийн наадам Ховд аймагт зохион байгуулагдлаа. Тус чуулга уулзалтанд нийт 4 мэргэжилтэн, 27 хүүхдийн хамт амжилттай оролцлоо. Тариалан сумын бүжгийн хамтлаг алтан медаль, чулуун хөгжим, ардын гоцлол дуугаар тус бүр мөнгөн медаль хүртлээ.	50
2.5.7	2	Алслагдсан болон говийн бүсийн байгалийн хүнд нөхцөлд ажиллаж амьдарч байгаа иргэдэд нийгмийн хөнгөлттэй үйлчилгээ үзүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ	Аймгийн түвшинд алслагдсан сумдын нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд эм, хоол хүнс, дулаан хувцас олгохоор төсөл хэрэгжүүлж байгаа гадаадын төслийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	50

2.5.9	1	Сургуулийн дотуур байр, эмнэлэг, соёлын төвийг шинээр барих буюу өргөтгөж засварлах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ	Зүүнговь, Өлгий, Баруунтуруун, Тэс, Өмнөговь сумдад дотуур байрны барилга шинээр барьж 100%, Завхан, Давст, Түргэн, Өндөрхангай сумдын, Улаангом сумын Чандманы өрхийн эмнэлгийн барилга шинээр барьж 100%, Баруунтуруун, Өлгий, Өндөрхангай сумын соёлын төвийг шинээр барьж 75%, Бөхмөрөн, Сагил, Өмнөговь, Тариалан, Завхан, Зүүнговь сумдын дотуур байрны барилгыг засварлаж, 85.7%, Давст, Түргэн, Наранбулаг, Тариалан сумын соёлын төвийг засварлаж 80%, эмнэлгийн 5 барилгыг засварлаж 100% тус тус биелэв.	90
2.1	1	Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг нэмэгдүүлнэ	2008 оны сүүлийн хагасаас хойших хугацаанд эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа өргөжиж байна. Мал нядалгааны цех 3 ашиглалтанд орж жилдээ 1300 тн мах экспортоллоо. Ногоо консервлах, чацаргана боловсруулах, сүү боловсруулах жижиг үйлдвэрүүд өргөжиж үйлдвэрлэлийн бүтэц сайжирч байна. Барилгын гүйцэтгэгч 10 аж ахуйн нэгж 18 барилгын объектод 2,7 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдээд байна. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр хананы материал, хучилтын хавтангийн үйлдвэр -3, замын өнгөт хавтангийн үйлдвэр -1, Вакуум цонхны үйлдвэр – 3 шинээр ажилд орлоо. Эдийн засгийн өсөлт нэмэгдэж зохих хэмжээний нөлөө үзүүлж байна.	50
2.1.2	1	Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Төсвийн хүрээний дунд хугацааны мэдээлэл. Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож дунд болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулна	Тус аймаг үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Увс аймгийг 2021 он хүртэл хөгжүүлэх стратегийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж түүнээсээ 2012 он хүртэл хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө гаргаж түүнийгээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган нийт 328 багц асуудлыг шийдэхэд 81,3 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийхээр төлөвлөж жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэлд тусган хэрэгжүүлж байна.	50
	2	Ажилгүйдэл ядуурлыг бууруулж иргэдийн амьдралын түвшин дээшлүүлэх үндэсний тооцооны шалгуур үзүүлэлт, тэдгээрийн түвшин, хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн тэнцвэрийг бататгах макро эдийн засгийн зохицуулалтын орчинг сайжруулна	Ажилгүйдэл ядуурлыг бууруулж иргэдийн амьдралын түвшин дээшлүүлэх үндэсний тооцооны шалгуур үзүүлэлт, тэдгээрийн түвшин, хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн ажлыг орон нутгийн түвшинд судлан жил бүрийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх зорилтод тодорхой асуудлыг үе шаттайгаар тусган хэрэгжүүлж байна. Сумдад үүн ээлжинд хөгжүүлэх 91 үйлдвэрийн жагсаалтыг батлан, ЖД Ү-ийг хөгжүүлэх сангийн зээлд 127 төслийг хамруулан 1413,3 сая төгрөгийн зээл олгож, үүний үр дүнд 57 жижиг үйлдвэр байгуулагдаж, 318 ажлын байр шинээр бий болсон.	70
	6	Улсын төсвийн болон Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв хотуудын зорилтот хөтөлбөр, төсөл арга хэмжээтэй уялдуулан хуваарилж хэрэгжүүлнэ,	2009-2010 онд улсын болон орон нутгийн төсөв зээл, тусламжийн хөрөнгөөр нийт гүйцэтгэлээр 38,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдээд байна. 2010 онд сумуудад 630 орчим сая төгрөгийн ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг зохион байгуулах эрхийг шилжүүлэн өгсөн. Энэ нь тус аймгийн стратегийн хөгжлийн хөтөлбөр, бүсийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлж байгаа чухал арга хэмжээ юм.	70

2.1.10	1	“Хувийн хэвшлийн хөгжлийн стратеги”-ийг батлуулан төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна,	Аймгийн ХАУТанхим, ажил олгогчд эздийн холбоотой аймгийн Засаг дарга түншлэлийн гэрээ байгуулан хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Аймагт бодлогоор хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг тендерээр ил тод шалгаруулах, ЖДҮ-ийн сангаас олгох зээлийн дэмжлэгийн төсөл шалгаруулах замаар шийдэж хэвшлээ.	30
2.1.27	3	Шудрага өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ	“Хэрэглэгчдийн эрх ашиг хамгаалах” ажлыг тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтсийн ажилтны ажлын байрны тодорхойлолтонд нэмж тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Энэ жилийн хувьд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийх ажил төлөвлөн хэрэгжүүлж байна. “ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах” аймгийн дэд боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.	50
	4	Зах зээлийн өрсөлдөөний тухай ойлголт соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, үндэсний болон олон улсын хэмжээний хурал семинар зохион байгуулна	Улс бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан хөрөнгө оруулалт, зах зээлийн соёлыг төлөвшүүлэх сургалт зөвлөгөөнд оролцож байна. 2009 онд Улаанбаатар, Ховд хотуудад зохион байгуулагдсан арга хэмжээнүүдэд бүс нутгийн хөгжлийн тухай илтгэл тавьж оролцлоо. 2010 онд Говь -Алтай аймагт зохион байгуулсан баруун бүсийн зөвлөгөөнд оролцож, баруун бүсийн аялал жуулчлалын хөгжлийн асуудлаар илтгэл тавьж оролцлоо. 2010 оны 10-р сард Улаанбаатар хотод Увс аймгийн эдийн засаг, хөгжлийн форум зохион байгуулж, аймгийн хөгжлийн гарцын асуудлаар 16 эрдэмтэн, судлаачид илтгэл тавьсан.	70
2.1.28	4	Бүсийн болон аймгийн төвд сорилт, хэмжил зүйн үйлчилгээг нэг цэгийн зарчимд шилжүүлнэ. Хэрэглээний зүйлс, барилга, хүрээлэн буй чанар, аюулгүй байдлын сорилт шинжилгээг орчин үеийн шаардлагын хэмжээнд хийдэг сорилтын лабораторийн үндэсний тогтолцоог бий болгоно	Тус аймагт сорилт шинжилгээ хэмжилзүйн үйлчилгээ мэргэжлийн хяналтын үйл ажиллагаатай давхцахгүйгээр Стандарт хэмжил зүйн хэлтэст төвлөрөн явагдаж байна. Хэрэглээний зүйлс, барилга, хүрээлэн буй чанар, аюулгүй байдлын сорилт шинжилгээг орчин үеийн шаардлагын хэмжээнд хийдэг сорилтын лабораторийг бий болгох зорилгоор аймгийн хэмжил зүйн хэлтэс шаардлагатай зарим тоног төхөөрөмжөөр хангахаар үнийн судалгаа хийж, аймгийн Засаг дарга тодорхой зардлыг шийдсэн.	50
2.2.5	1	Боловсруулах үйлдвэрийн салбаруудыг хари лцан уялдаа бүхий хоршилт, төрөлжсөн хэлбэрээр хөгжүүлж эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах цогцолборууд байгуулна	Аймгийн хөгжлийн стратегийн төлөвлөгөөнд боловсруулах салбарыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг оруулж түүнээс түлхүү хөгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэрлэлийн салбарыг тодорхойлж ЖДҮДС, хөгжлийн сан зэргээс дэмжиж ажиллаж байна.	30
	2	Газар зүйн заалттай бүтээгдэхүүн бий болгох ажлыг эрчимжүүлж нэр төрлийг олшруулна	Газар зүйн заалттай бүтээгдэхүүн бий болгох бэлтгэл ажлын хүрээнд аймагт “Чацаргана” хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар батлуулж хэрэгжүүлж ажиллаж байна. Увсын чацарганы бүтээгдэхүүнд Монгол улсын шилдэг 99 бүтээгдэхүүний нэг болсон. “Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөтөлбөрийн хүрээнд жамц давс, арвайн гурилыг брэнд бүтээгдэхүүнээр тодруулсан. Жил бүр аймгийнхаа үйлдвэрлэгчдийг сурталчлах зорилгоор	70

			Увс түншлэл үзэсгэлэн худалдааг зохион байгуулж улмаар баруун бүс улсын хэмжээний үзэсгэлэн худалдаанд жил бүр оролцож байна. Газар зүйн заалт авч болох брэнд бүтээгдэхүүний судалгааг сум бүрээр гаргаж тухайн бүтээгдэхүүнүүдийг сурталчилж ажиллаж байна.	
	3	Салбарын эрдэм шинжилгээний байгууллагын чадавхийг дээшлүүлэн шинжлэх ухаан үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлнэ	Газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн статусыг өөрчилж ХАА-н их сургуулийн харьяанд шилжүүлэх саналыг холбогдох яамдуудад уламжилж, хамтран ажилласны үр дүнд тус аймаг дахь УГТЭШХүрээлэнг ХААИС-ын ректорын тушаалаар ХААИСургуулийн харъяа баруун бүсийн ХААЭШХүрээлэн болгож шинэчлэн зохион байгууллаа.	70
	4	Боловсруулах үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилчин, инженер техникийн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр баталж хэрэгжүүлнэ	Аймгийн хэмжээнд Хөдөлмөрийн дээд сургуулийн салбар, Улаангом коллежийн мэргэжлийн ангид болон түр хугацааны сургалтуудад хүмүүсийг сургаж мэргэшүүлэх ажил хийж байна.	30
2.2.6	1	Уул уурхайн үйлдвэрийг түшиглэн барилгын материалын үйлдвэр орон нутагт байгуулахыг дэмжинэ,	Орон нутагт байгаа орд газруудыг ашиглан, элс ,хайрга, шохой, тоосго, хавтангийн зэрэг барилгын материалын 5 жижиг үйлдвэрийг шинээр барьж байгуулахад дэмжлэг үзүүллээ. Өмнөговь суманд тоосгоны үйлдвэр байгуулах төсөл шалгаруулах зар төвийн хэвлэл мэдээлэлд тавьж шалгуурлалтын ажил зохион байгуулав. Жижиг үйлдвэр байгуулах төслийн хүрээнд зээл хүсэж холбогдох байгууллагад санал тавиад шийдвэрлэгдээгүй байна. “Баянцагаан зам” ХХК-д үйлдвэр барих газар, тоосгоны орд газрын зөвшөөрөл, лицензи олгуулахаар сумын удирдлагатай тохироод байна.	50
2.2.28	1	“Сүү хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж махны нөөцийн сан байгуулна	Сүү, сүүн болон мах махан бүтээгдэхүүнийг боловсруулах, махны нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Сүү тээвэрлэх зориулалттай тоног төхөөрөмж авах захиалгаа ХХААХҮЯам болон холбогдох газруудад хүргүүлсэн. Аймгийн төвд мах хадгалах зориулалттай 3 зоорь ажиллаж байна. “Мах маркет” ХХК гүн хөлдөөх 20тн, ердийн 200тн, “ Бум номин “ ХХК гүн хөлдөөх 10 тн, ердийн 90тн, “ Мон тува “ гүн хөлдөөх 10 тн, өйд 120 тн мах нөөцлөх боломжийг бүрдүүллээ. Засгийн газрын 2010 оны 138 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд махны нөөц бүрдүүлэх зорилгоор ИТХ-аар 50.0 сая төгрөг батлуулсан	70
2.2.30	1	“Чацаргана” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ	Тус аймаг 2005 оноос “Чацаргана” хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна. 2009 онд Аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдаанаар хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай хэлэлцэж эхний шат амжилттай хэрэгжсэн гэсэн үнэлэлт дүгнэлт өгч хоёр дахь шатны зорилтыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болно. ХХААХҮЯ-аас зарласан тендерт 2 компани шалгарч 200.0 мянган чацарганы суулгац бэлтгэн нийлүүллээ.	70

2.3.1	2	Сүүний хангамжийг нэмэгдүүлэн сүү сүүн бүтээгдэхүүний чанар. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулан, удаан хугацаагаар хадгалагдах сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ	Сүү, сүүн болон мах махан бүтээгдэхүүнийг боловсруулах, махны нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Сүү тээвэрлэх зориулалттай тоног төхөөрөмж авах захиалгаа ХХААХҮЯам болон холбогдох газруудад хүргүүлсэн.	50
	3	Малчид, фермерүүдийн сүү үйлдвэрлэгчид нэгдсэн байдлаар цуглуулах, хөргөх, боловсруулах сүү бэлтгэлийн тогтолцоо бүрдүүлэн ажлын байр нэмэгдүүлж хүн амын амьжиргаа, хүнсний аюулгүй байдлыг хангана	Малчид, фермерийн сүү цуглуулах зориулалттай тоног төхөөрөмж ханган нийлүүлэх захиалгыг авч нэгтгэн ХХААХҮЯаманд хүргүүлсэн. Алтай соёны төслийн хөрөнгө оруулалтаар Сагил, Түргэн, Тариалан, Ховд, Улаангом сумдын 5 малчдын бүлэг, нөхөрлөлд 1.7 сая төгрөгний өртөг бүхий сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах бага хүчин чадлын тоног төхөөрөмж нийлүүлснээр шинээр ажлын байр 10-аар нэмэгдэж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулж, худалдан борлуулж малчдын бүлэг, нөхөрлөлийн эдийн засгийн чадамж сайжирч, дундын сандаа хуримтлал бий болгож байна. Өнгөлөг-трейд ХХК-д хуурай сүүний үйлдвэр байгуулахад 80.0 сая төгрөгний зээлийн дэмжлэг үзүүлсэн	50
	5	“Ногоон хувьсгал” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	“ Ногоон хувьсгал” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, анхан шатны мэдлэг олгох зорилгоор богино хугацааны семинар, сургалт зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрч үр тариа, жимс, жимсгэнэ, чацаргана эрхлэгчид 20-45%-иар нэмэгдэж, хүн амын хүнсний хангамж нэмэгдэх боломж бүрдэж байна. “Ногоон хувьсгал хөтөлбөр”-ийн хүрээнд 2010 онд 20 аж ахуйн нэгж 1256 гаруй иргэн 450 га талбайд төмс, хүнсний тариалалт хийж 7620 тн ургац хурааж авсан нь өмнөх онтой харьцуулахад аж ахуйн нэгж 3, өрхийн тоо 42-оор өсч, хураасан ургац 3870 тн-оор нэмэгдлээ. Аймгийн хэмжээнд 92 зоорь ашиглагдаж байгаа бөгөөд 970 тн ургац хадгалах боломжтой. 2010 онд 510 тн багтаамж бүхий 17 зоорь шинээр баригдаж ашиглалтанд орлоо. Төмс, хүнсний ногооны хэрэгцээ аймагтаа бүрэн хангаж байна.	90
	6	Дотоод хүнсний түүхий эдэд тулгуурласан нярай хүүхдийн хоол тэжээлийн болон түүнд чиглэсэн үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ	Бага насны хүүхдийг хоол тэжээлийн архаг дутагдлаас сэргийлэх зорилгоор олон нийтийн арга бэлдмэлээр хангах ажлыг үе шаттайгаар орон нутгийн түвшинд хэрэгжүүлж байна.	30
2.3.5	1	Тариалангийн талбайн бүртгэл тооллого явуулж эзэмшилт ашиглалтыг сайжруулна	Газрын алба, ХХААЖДҮГ хамтран тариалангийн талбайн тооллого бүртгэлийг 2008 онд хийсэн. Цаашид атаршсан газрыг ашиглах, одоо ашиглаж байгаа талбайн эзэмшилт ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийт тариалангийн талбай 45543.3 га үүнээс тариалсан талбай- 5598 га, атаршсан газар – 11032, өнжөөсөн талбай- 28913.3 га. Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн зохион байгуулж, тариалангийн талбайн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах, агротехник, усалгааны норм, горимыг чанд мөрдөж ажиллах талаар тариалан эрхлэгчдэд сургалт, семинар зохион байгуулж, заавар зөвлөмж өгөх ажлыг зохион байгууллаа.	90

2	Таримал ургамал, үр үржүүлгийн аж ахуй байгуулах, үрийн сорт нэр төрлийг олшруулах, ганд тэсвэртэй болон усалгаатай нөхцөлд тариалах сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ	Таримал ургамлын үр, жимс жимсгэний үр, суулгац үржүүлэх, улмаар тус аймагт үрийн аж ахуй бий болгох санлыг ХХААХҮЯ, холбогдох газруудад хүргүүлж, Ерөнхий сайд, ХХААХҮ-ийн сайд, дэд сайд нар тус аймагт ажиллах үед үр үйлдвэрийн үйл ажиллагааг танилцуулсан. Кондицын шаардлага хангасан сайн чанарын үр суулгац үйлдвэрлэх ажлыг мэргэжлийн байгууллагын хяналтан дор хэрэгжүүлж байна. Усалгаатай нөхцөлд тариалах үр тарианы Цагаан дэглийн 50 тн үрийн нөөц бий болгосон. Төмсний Астили, Импала, Ветера, Накала сортын 156 тн үр, Шар лууван, шар манжин, сонгино, хүрэн манжины 50-80 тн үр үйлдвэрлэж хүнсний ногооны үр, жимс, жимсгэний суулгацаар өөрийн аймгийн хэрэгцээг бүрэн хангаж байна. Үр тарианы Казакстан, Дархан -84,139, 106, Оскар, Чагытай, овъёосны Крупнозерны, Нудум, Фобос сортуудыг сорт сорилтонд тариалж байна. Цэвэр сортын хүнсний ногооны үр үйлдвэрлэгч албан байгууллага-1, иргэн-29, суулгац үржүүлэгч -2 иргэнд тусгай зөвшөөрөл олголоо	90
3	Улаан буудайн нөөц бүрдүүлэх хүрэлцээ хангамжийг сайжруулах зорилгоор борлуулалтын сүлжээ бий болгоно	Баруунтуруун дахь улсын нөөцийн салбарт улаан буудайн үрийн нөөц бий болгож иргэн, аж ахуйн нэгжүүдэд захиалгын дагуу олгох ажлыг зохион байгуулж байна. 2008 онд 250 тн улаанбуудайг Баруунтурууны улсын үрийн нөөцөд авсан. 2009 онд үрэнд буудай аваагүй. 2010 онд гэрээ хийх шатандаа явж байна.	30
4	“Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ	“Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хүрээнд: Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр тариалан эрхлэгч 31 иргэн, аж ахуйн нэгжид 500.0 сая төгрөгний хүүгүй зээлийг гурвалсан гэрээ байгуулан олгож, төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Агро парк төслөөр 30тн-ын багтамжтай зоорь, 120м ² талбай бүхий хүлэмж-19ш, бага оврын трактар- дүүжин чиргүүл агрегатын хамт 12 ш-г олгож 190.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн. 2009 оноос уринш боловсруулалтанд хүүгүй хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг шийдвэрлэлээ. 2009 онд 1200 га-д, 2010 онд 2000 га-д уриншийн боловсруулалт хийгдлээ. Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, лизингийн аж ахуй байгуулах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээгээр ХАА-н техник тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Үүнд: Үр тарианы комбайн – 3ш, өндөр хүчин чадал бүхий трактор беларус- 1221-5ш, багаоврын МТЗ- 82,1 трактор- 2ш, үр тарианы үрлүүр СКП- 2,1 -15ш, үр тариа цэвэрлэгч - САД-10 4ш, хор цацагч- ОП- 2000-18 -1ш, хаван сийрүүлэгч лидер-4-5ш, үр тариа ачигч- МЗС- 100 -2ш. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд техникийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор орон нутгийн өмчит “Хатан түрүү” ХХК байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлд ажилагсадын мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэдээлэл өгөх, чадамж, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, заавар зөвлөмж гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Улаангом коллежийн дэргэдэх “Судалгаа – сургалт- үйлдвэрлэлийн төв”, АЗДТГ, УГТЭШХ,	90

			ХХААЖДҮГ хамтран “ Увс аймгийн газар тариалангийн шинэ техник технологи, тэргүүн туршлага” сэдэвт онол үйлдвэрлэлийн бага хурал зохион байгуулж, тавигдсан илтгэлүүдийг шалгаруулж эхний 3 байрт орсон илтгэгч нарт урамшуулал олголоо.	
	5	Улаан буудайн үйлдвэрлэлд төрөөс дэмжлэг хэлбэрээр үзүүлэх урамшуулалын системийг боловсронгуй болгоно	Улаан буудай үйлдвэрлэгчдээс буудайг гурилын үйлдвэрт хүлээн авч урамшуулал олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2008 онд гурилын үйлдвэрт “ Арвижих –Увс” ХХК-482тн, “Алтан- дуулга” ХХК- 325тн, Баруун туруун сумын 3 аж ахуйн нэгж, 32 иргэн- 650тн, 2009 онд гурилын үйлдвэрт “ Арвижих –Увс” ХХК- 500 тн, “Алтан- дуулга” ХХК-414тн, Баруун туруун сумын 4 аж ахуйн нэгж, 40 иргэн-1040тн буудайг тушаасан	50
2.3.6	1	Нутгийн болон сайжирсан цэвэр үүлдрийн малын удмын сан хамгаалах, өсгөх, мал үржүүлгийн болон био технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлнэ	Баяд үүлдрийн хонь, өлгийн улаан омгийн ямаа, тэс хэвшлийн адууг өсгөн үржүүлж өөрийн аймаг болон бусад аймгуудад худалдаалах, шилмэл малын үзэсгэлэн үнэ хаялцуулах худалдаа зохион байгуулах ажлыг тогтмол хийж байна. 2009 онд Баяд үүлдрийн хурган хуц-680, охин төлөг-200, Өлгийн улаан омгийн ухна- 130, Тэс хэвшлийн азарга- 60, Гүү- 40 –г тус тус сайжруулагчаар бойжуулсан Энэ онд Архангай, Завхан, Говь-алтай, Ховд аймгуудад Баяд үүлдрийн хурган хуц -1667, Өлгийн улаан омгийн ухна 150 ш-г сайжруулагчаар бойжуулж худалдлаа. 2010 онд 2500 баяд үүлдрийн хурган хуц, 500 ухна шинээр бойжуулж байна.	70
	2	Цаа буга, тэмээний удмын сан эрүүл мэндийг хамгаалах, ашиг шимийг зохистой ашиглах замаар цаачид, тэмээчдэд дэмжлэг үзүүлнэ	Тэмээн сүргийн удмын санг хамгаалах , өсгөн үржүүлэх , ашиг шимийг нэмэгдүүлэх, тэмээчдийг урамшуулах бодлого баримтлан ажиллаж байна. 2009-2010 онд 2 сумын 1659 тэмээнд үзлэг ангилалт хийж ,аймгийн хэмжээнд 547 тэмээ цөм сүрэгт бүртгэгдсэн байна.Аймгийн аварга , тэргүүн шалгаруулах журамд тэмээчдийн ажлын үзүүлэлтийг оруулан шалгаруулан шагнаж урамшуулж байна. Жил бүр Завхан суманд тэмээний баяр зохион байгуулж байна.	50
	3	Цөм сүргийн малыг үржлийн бүртгэлд бүрэн хамруулж улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт цөм сүргийн малын удам гарваль, ашиг шимийн мэдээллийн сан бий болгоно	Хяргас, Малчин,Тэс,Зүүнговь сумдын хонь, Өлгий, Өмнөговь,Завхан сумуудын ямаа, Зүүнговь, Тэс, Өндөрхангай сумдын үхэрт үзлэг ангилалт хийсэн. Ангилалтанд 33824 ямаа,25965 хонь хамрагдаж 1 ба түүнээс дээш ангид 25420 толгой мал бүртгэгдсэн.Аймгийн хэмжээний бүх хээлтэгчид үзлэг аттестатчлал хийж бүртгэлтэй болгох ажлыг зохион байгуулсан.Баяд хонины стандарт шинэчлэх санал оруулах зорилгоор баяд үүлдрийн бүдүүн ба төлгөн хуц, охин төлгөнд хэмжилт хийж саналаа МААЭШХүрээлэнд хүргүүлсэн. Цөм сүргийн малын удам гарваль, үржлийн бүртгэл хөтөлж,,гэрчилгээжүүлэн, ээмэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэдээллийн сан бий болгож байна. Аймгийн хэмжээнд цөм сүргийн тэмээ- 547, Адуу-12428, Баяд үүлдэрийн хонь- 221094, Өлгийн улаан омгийн ямаа- 76146 толгой бүртгэгдэн үзүүлэлттэй байна.	70

	4	Малын үржлийн ажил үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулах зорилгоор цөм сүргийн үржлийн нэгжийн ажлын чадавгийг сайжруулах асуудлыг судалж холбогдох арга хэмжээ авна	Цөм сүргийн үржлийн төв болон ХХААЖДҮГ малын үржлийн ажил үйлчилгээг сайжруулах, цөм сүрэг бүрдүүлэх, МЭҮН-үүдийн ажил үйлчилгээг сайжруулах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Цөм сүргийн үржлийн төвийг Улсын үйлдвэрийн газар болгох саналаа холбогдох газруудад хүргүүлснээр ЦСҮҮҮГ болж үйл ажиллагаагаа явуулж байна. Баяд үүлдрийн хонь, Өлгийн улаан омгийн ямаанд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа. Өлгийн улаан омгийн ямааны ашиг шимийн үзүүлэлтийг хэмжих, үржлийн хээлтэгч, хээлтүүлэгчийг нөхөж тавих зорилгоор Өлгий сумын Чаргат, Хулст нуур, Өлгий нуур багийн 30 эм ямаа, 30 борлон, 30 уханд үзлэг ангилалт хийж, ноолуурын гарц тогтоох, дээж авах, биеийн үндсэн хэмжээнүүдийг тогтоох ажил хийгдлээ.	90
2.3.7	1	Эрчимжсэн мал ахуй эрхлэх бүс нутгуудыг аймаг сум бүрээр тусгайлан тогтоож, тухайн бүс нутагт буй бэлчээрийн малыг өндөр ашиг шимт малаар сольж, өөрчлөх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ	Аймгийн стратеги хөгжлийн хөтөлбөрт энэ чиглэлийн асуудлыг тусган хэрэгжүүлж байна. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Улаангом сумын Гашууны гол, Бор үзүүрийн чиглэлийг эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс болгон тогтоосон. Гашууны голд сүүний чиглэлийн өндөр ашиг шимт үхрийн фермерийн аж ахуй-1, нутгийн үүлдрийн үхрийн аж ахуй-3 шинээр байгуулагдаж, Улаангом сумын иргэдэд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлчилгээ үзүүлж байна. “Мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах” аймгийн дэд хөтөлбөр, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж ИТХТ-ийн 2010 оны 8 дүгээр сарын 13-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. ЖДҮ-ийг дэмжих сангаас эрчимжсэн МАА эрхлэх 3 сумын 4 иргэнд 34 сая төгрөгний зээлийн дэмжлэг үзүүллээ.	70
	2	Сүү махны арвин ашиг шимт мал амьтны тоог нэмэгдүүлэх, үржлийн сүрэг бий болгох үйл ажиллагааг урамшуулна	Сүү, махны ашиг шимт мал сүргийн тоо толгойг өсгөх, үржлийн шилмэл сүрэг бий болгох зорилгоор ЖДҮ-ийг дэмжих сангаас зээл олгох, хөнгөлөлттэй нөхцлөөр техник тоног төхөөрөмж нийлүүлэх, инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргахад нь дэмжлэг тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. Улаангом суманд өндөр ашиг шимт үхэр – 35 Улаангом, Сагил, Зүүнговь, Давст зэрэг сумдад өндөр ашиг шимт болон нутгийн үүлдрийн үхэр – 75 толгойгоор нэмэгдлээ. Сүү махны чиглэлийн малын тоо толгойг өсгөх, үржлийн сүрэг бий бологох үйл ажиллагааг нь идэвхжүүлэх зорилгоор оны аварга тэргүүн шалгаруулах журамд фермерийн үзүүлэлтийг нэмж тусгалаа.	70
	3	Бүсийн тулгуур төв болон орон нутгийн хөгжлийн төвүүдийн ойролцоо фермерийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлэх загвар бий болгоход дэмжлэг үзүүлнэ	Аймгийн төвийн ойролцоо болон хүн ам олноор төвлөрсөн Улаангом, Тариалан, Түргэн, Сагил, сумдад фермерийн болон жижиг амьтдын загвар аж ахуй болгоход дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас сүү, махны чиглэлийн үхэр, хонь, ямааны фермерийн аж ахуйг хөгжүүлэх 5 төсөлд- 62.5 сая, мах, үржлийн чиглэлийн хонь үржүүлэх 2 төсөлд- 15 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн. Үнээний фермерийн загвар аж ахуй 1 байгуулагдлаа. Улаангом суманд мах сүүний	70

			чиглэлийн үхрийн аж ахуй, сүүний болон үржлийн адууны фермерийн АА-д 22.0 сая төгрөгний зээлийн дэмжлэг үзүүллээ.	
2.3.8	1	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж байгуулан ажиллуулна	Аймгийн ИТХ-ын ээлжит 4 дүгээр хуралдаанаар батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн худалдах тусгай зориулалтын зах байгуулахаар тусган бэлтгэл ажил хийгдээд байна. “Хөдөө аж гаралтай түүхий эд бэлтгэх” бирж байгуулах бэлтгэл ажлыг хангах, хяналт тавих, үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2010 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 218 дугаар захирамжаар баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Улаангом руу орох 3 чиглэлийн замд” Мал, түүхий эдийн зах” байгуулах тендер зарлан эзэнжүүллээ	30
	2	Сум бүрт түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршоо нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ	Сумдыг бүсчилэн хөгжүүлэх бодлогын хүрээнд бүсийн төв сумуудад энэ чиглэлийн хоршоо, нөхөрлөлийг байгуулахад дэмжлэг үзүүлэх бодлого баримталж байна. Алтай соёны төсөл, Мерси-кор, ДБХС-ийн санхүүжилтээр Ховд, Улаангом, Түргэн,Сагил,Бөхмөрөн сумдын малчдын 32 бүлэг, нөхөрлөлд мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх талаар үе шаттай сургалт зохион байгуулж, бага хүчин чадлын тоног төхөөрөмжийг хөнгөлтэй үнээр олгох, хоршоо, бүлэг, нөхөрлүүдэд зээл олгох зэрэг дэмжлэг үзүүлснээр сүү сүүн бүтээгдэхүүн, эсгий эсгий эдлэл, зээгт наамал, арьс шир, ноос ноолуур боловсруулж нөхөрлөлийн гишүүдийн хэрэгцээг хангаж илүүдэл бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулж дундын сангаа арвижуулах боломж бүрдэж байна. Алтай соёны төсөл, Мерси кор, ДБХС хамтран 2010.10.07- 09 –ний өдрүүдэд Улаангом суманд “ Нөхөрлөл хөгжлийн түншлэл – 2010” туршлага солилцох уулзалт, үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа.	50
2.3.10	1	“Малын тэжээл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	Хүн хүч, өвс хадлангийн нөөцтэй Тариалан, Наранбулаг, Тэс, Баруунтуруун, Сагил сумдад тэжээлийн бага оврын үйлдвэр байгуулах саналаа ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. 2009 онд өвс- 42324 тн, гар тэжээл- 1973 тн, сүрэл- 856,9 тн тус тус бэлтгэсэн.” Малын тэжээл “ хөтөлбөрийн хүрээнд: Малчин сумын “Баянмандал” “ Улаанбулаг” хоршоонууд төсөл хэрэгжүүлэн зээлэнд хамрагдаж 30 га талбай хашиж 115 тн ургац хурааж малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүллээ. “ Тогтвортой амьжиргаа- II “ төслийн санхүүжилтээр хадлангийн талбайг хашиж хамгаалах замаар малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлийн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Үүнд: 2009 онд 534 га талбай хашиж хамгаалах 34 төсөлд 158.6 сая төгрөг, 2010 онд 138 га талбай хашиж хамгаалах 14 төсөлд 48.7 сая төгрөг Аймгийн хэмжээнд жил бүр 48.0- 50.0 мянган тн байгалийн хадлан, 1650-1820 тн гар тэжээл, 865- 1200 тн таримал тэжээл, 1200-1500 тн хивэг үйлдвэрлэж байна.	70
	2	Хадлан болон тэжээл үйлдвэрлэлд дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, тэжээлийн хангамж, чанарыг сайжруулах, хадгалалт тээвэрлэлтийн зардлыг бууруулах арга хэмжээ авна	Хадлангийн зориулалттай бага оврын техник тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэх, хадлангийн нөөц бүхий Тэс, Бөхмөрөн, Ховд, Хөндлөнгийн голын ай сав газрын хадлангийн талбайг иргэдэд эзэмшүүлэх замаар хадлангийн нөөц бий болгох,чанар хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.Тариалан сумын “ Алдар тулга” хоршоо, иргэн Г.Самбуу нарт тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж шинэчлэх төсөлд жижиг, дунд	70

			<p>Үйлдвэрийг дэмжих сангаас 25.0 сая төгрөгний зээлийн дэмжлэг үзүүлж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурилууллаа. Баруунтуруун, Тариалан сумдад 108 га талбайд царгас тариалж 300тн, “Алдар тулга” хоршоо энгийн усалгаатай талбайг усалж тордон жил бүр 10000 гаруй боодол царгас бэлтгэн малчид мал бүхий иргэдийн хэрэгцээнд нийлүүлж, малын тэжээлийн хангамжийг нэмэгдэх, тээврийн зардал, өвсний үнэ ханш буурах боломжийг бүрдүүлж байна. Бэлтгэсэн хадлан, тэжээл тээвэрлэн авах зардалд Засаг даргын нөөцөөс сум бүрт 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>	
2.3.11	3	<p>Аймгийн болон сум дундын отрын бүс нутгийг өргөжүүлж материаллаг баазыг бэхжүүлнэ. Отрын бүс нутгийн бэлчээрийн нөхөн сэргээлт, хамгаалалтыг сайжруулан зохистой ашиглах арга хэмжээ авна</p>	<p>Аймаг дундын отрын бүс нутаг тогтоох судалгааг хийж байна. Бөхмөрөн, Ховд сумдын Бумбын хулс, Бурхадын улаан, Завхан сумын Дааган дэл, Үнэгтийн хөндийн бэлчээр нутгийг сум дундын отрын бүс болгосон болно.</p>	70
2.3.12	2	<p>Хил дамжин халдварладаг малын гоц халдварт шүлхий, хонь ямааны цэцэг, гахайн мялзан, шувууны томуу өвчний дэгдэлтээс эрт сэрэмжлүүлэн, хариу арга хэмжээ хэрэгжүүлэн уг өвчнөөр тайван нөхцлийг хангаж ажиллана</p>	<p>Хил дамжин халдварладаг малын гоц халдварт шүлхий, хонь ямааны цэцэг, гахайн мялзан, шувууны томуу манай улсын хил залгаа ОХУ, БНХАУ-улсад гарч байгаа төдийгүй манай улсад 1 жилийн өмнө хонь ямааны цэцэг өвчин гарч байсныг МЭҮН-ээр дамжуулан малчдад мэдээлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулж байна. Улаангом суманд байгаа гэрийн тэжээвэр шувуудад томуугаас урьдчилан сэргийлэх вакцин тарьсан ба Увс, Хяргас, Үүрэг, Ачит, Баяннууруудад шувууны томуугийн тандалт судалгааг энэ оны 8 сард хийсэн.</p>	30
	6	<p>“Мал эмнэлэг үржлийн анхан шатны үйлчилгээний нэгжийг дэмжих хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлж, сум дүүргийн мал эмнэлэг үржлийн анхан шатны нэгжүүдийг бэхжүүлнэ</p>	<p>“Мал эмнэлэг үржлийн анхан шатны үйлчилгээний нэгжийг дэмжих хөтөлбөр”-т тусгах саналаа боловсруулсан. Сумдын МЭҮ-ний анхан шатны нэгжүүдийн эзэд болон ХАА-н асуудал хариуцсан ажилтнуудыг оролцуулан семинар, зөвлөгөөн зохион байгуулж, Сумын Засаг дарга, МЭҮН, ХХААЖДҮГ хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>	30
2.3.13	3	<p>400 худаг шинээр гаргаж 1000 худаг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлнэ</p>	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлээр шинээр 14 худаг, төслөөр 1 худаг гаргаж гадна барилга байгууламжийг бүрэн барьж ашиглалтанд хүлээлгэж өгсөн. 2010 онд инженерийн хийцтэй 17 худаг гаргах тендер зарлаж Ус-эрдэнэ ХХК, Энержи флоу констракшн шалгарч “Ус-эрдэнэ” ХХК 8 худаг, Энержи-флоу констракшн 9 худаг гаргалаа. “Тогтвортой амьжирга –II” төслийн санжүүжилтээр Хяргас, Наранбулаг, Ховд сумдад бэлчээрийн зориулалттай энгийн хийцтэй худаг 1ш худаг шинээр гаргаж, 6 худаг сэргээн засварлав. Төсвийн тодотголоор Зүүнхангай сум, ХЦ-ийн 0245 ангид тус бүр 1 худаг шинээр гаргасан.</p>	90
	4	<p>Газрын доорхи усны геофизикийн хайгуул хийж 1600 уст цэг шинээр тогтооход дэмжлэг үзүүлнэ</p>	<p>Бэлчээрийн усан хангамжийн чиглэлээр тус аймагт 2008 онд 50 цэгт уст цэгийн хайгуулын ажил хийгдсэн. 2009-2010 онд санхүүжилт тусгагдаагүй.</p>	30
	5	<p>Жил бүр 100 мянган га-д царцаатай, 500-аас доошгүй мянган га-д мэрэгчтэй тэмцэх ажлыг гүйцэтгэж мал аж ахуйн</p>	<p>Жил бүр дундачаар 10-с доошгүй мянган га-д царцаатай тэмцэх, Давст, Зүүнхангай, Өндөрхангай сумдын нутагт мэрэгчтэй тэмцэх ажлын саналыг холбогдох яамдад хүргүүлсэн. 2008 онд бэлчээрийн</p>	70

		үйлдвэрлэлд ашиглах бэлчээрийг нэмэгдүүлнэ	хортон царцаатай тэмцэх ажлыг Түргэн суманд 12.5 мянган га-д, Наранбулаг суманд 7.5 мянган га-д, 2010 онд Цагаанхайрхан, Малчин, Хяргас сумдын бэлчээрт царцааны тархалтын судалгаа хийж, зураглал гарган царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулж Эдгээр сумдын 22.0 мянга га бэлчээрт хор цацаж, технологийн дагуу устгалын ажлыг хийж гүйцэтгэлээ. Давст сумын Торхилог багийн нутаг дэвсгэр, Хатуугийн уул орчмын 15.0 мянган га бэлчээрт үлийн цагаан оготны тархалтын зураглал хийлгэж, дүгнэлт гаргуулах тухай саналыг ХХААХҮЯ-нд хүргүүллээ.	
	6	Газрын төлбөрийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хуулийн төсөл боловсруулна	Газрын төлбөрийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хуулийн төсөлд оруулах саналыг хүргүүлсэн болно.	100
2.3.14	1	“Хоршоог дэмжих хөтөлбөр” хэрэгжүүлж мал борлуулах, түүхий эд бэлтгэх чиглэлээр сум дүүрэг тосгодод иргэдийн нөхөрлөл хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлнэ	Тус аймагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар сумдад хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэг байгуулах, малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах анхан шатны цех байгуулах, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мерси кор, Алтай соёны төслүүд, аймгийн хоршоодын холбооноос иргэд, аж ахуйн нэгжүүд хоршоо, нөхөрлөл малчдын бүлгийг шинээр байгуулах талаар заавар зөвлөмж өгөх, гарын авлага материалаар хангах ажлыг зохион байгуулж байна. Нөхөрлөл хоршооны бүтэц, үйл ажиллагааны талаар сургалт сурталчилгаа зохион байгуулж байна. ДБХ сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр 14 малчдын бүлэг, нөхөрлөл шинээр байгуулагдлаа.	70
2.3.16	1	“Мал сүргийг зарим зооноз халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлж өрх баг сум дүүрэг аймгийн түвшинд эрүүлжүүлэлтийг баталгаажуулан гэрчилгээжүүлэх арга хэмжээ авна	“Малын эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Зооноз өвчин болох боом өвчнөөс сэргийлэх вакцинийг аймгийн хэмжээнд 29600 бод, 258900 бог малд, Давст, Сагил, Бөхмөрөн сумдын 36670 хээлтэгч, хээлтүүлэгч малд бруцеллэзын шинжилгээ хийсэн. 2010 онд 9 сумын 2432 тэмээнд ийлдэс, бруцеллэзын шинжилгээ, Экто, эндо паразитанд- 137.0 мянган толгой мал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 942,9 мянган толгой мал хамрууллаа	70
2.3.17	1	Байгаль экологид сөрөг нөлөөгүй дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар өнжөөсөн болон атаржсан талбайг эргэлтэнд оруулна	Газар тариалан эрхэлдэг иргэн аж ахуйн нэгжүүдэд газар эзэмшүүлэх, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар атаршсан талбайг эргэлтэнд оруулах бодлого баримтлан ажиллаж байна. Орчин үеийн өндөр хүчин чадалтай ХАА-н техник тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр 2010 онд 1710 атаршсан болон өнжөөсөн талбайг эргэлтэнд орууллаа.	50
	2	Тэг болон цомхотгосон аргаар бэлтгэх, уриншийн хэмжээг 50 мянган га-д хүргэнэ	Газар тариалангийн үйлдвэрлэлд цомхотгосон аргаар боловсруулалт хийх аргын өргөн ашиглаж байна. 2009 онд Хар цагаан усанд 1200 га-д уринш хийсэн. 800 га-д эргүүлж, 200 га-д хавж, 400 га-д химийн уринш хийсэн. 2010 онд 2440 га-д уриншийн боловсруулалт, 190 цэвдэгш хагалгаа хийгдсэн.	70
2.3.18	1	Зоорь агуулахын төрөлжсөн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэн томоохон хотуудад хүнсний нарийн ногооны төрөлжсөн худалдааны зах, биржийн тогтолцоо бүрдүүлнэ	“Атрын гурав дахь аяны”-ны хүрээнд 19 сумдад 120 м ² хүлэмж, 30 тн-ын багтаамжтай зоорь баригдсан.	50

2.4.5	2	Монгол улсын иргэн бүрд үнэгүй өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна	<p>Увс аймгийн хэмжээнд Монгол улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх өмчлөлийн асуудал өссөн дүнгээр 4033өрхөд / иргэнд / 3947иргэний /өрх/ 404.18 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүй өмчлүүлсэн. 2010 онд аймгийн хэмжээгээр 250 иргэн эзэмшиж, ашиглаж байсан хашааны 25.98 га газраа, 59 өрх шинээр гэр хорооллын суурьшлын бүсээр төлөвлөгдсөн газраас 6.57 га газрыг тус тус бүгд 321 иргэнд 34.68 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлөн авсан байна. Энэ нь иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх хуулийн хугацааг 2013 он хүртэл сунгасантай холбоотойгоор иргэдийн газраа өмчлөн авах сонирхол буурч аймгийн хэмжээнд өмнөх үетэй харьцуулахад илт багассаныг харуулж байна.</p> <p>Аймгийн хэмжээгээр 2010 онд байдлаар өссөн дүнгээр 7315 газар өмчлөх өргөдөл хүлээж авсанаас 7003 иргэний 6987,0 га газрыг судалгааг шивж тухайн шатны засаг даргын захирамжийг үндэслэн нэгтгэн мэдээллийн санд оруулаад байна.</p>	50
	3	Нийслэлийг аймгийн төвүүдтэй холбосон улсын чанартай авто замуудын дагуу иргэдэд өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна	<p>“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсантай холбогдуулан Наранбулаг Тээл 4.3 га, Зүүнговь Зэл, Хар бураан хаяа 1 га, Зүүнхангай Хотгорын худаг 0.21 га, Цагаанхайрхан Морьтын ус 0.21 га, Тариалан Тээлийн гүүр 0.35 га, Өндөрхангай Уушигийн улаан 1 га газруудыг улсын чанартай зам дагуу өмчлүүлэх боломжтой газрын нарийвчилсан судалгааг гарган тогтоосон. 2010 оны ГЗБТ-нд улсын чанартай авто замын дагуух газарт өмчлүүлэхээр төлөвлөгөөнд тусгаагүй.</p>	50
	4	Аж ахуйн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан өмчлүүлэх газар тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтын газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна	<p>Аж ахуйн зориулалтаар газар өмчлүүлэх боломжтой газрын судалгааг гаргаж 19 сумдаас одоогийн байдлаар 5 сумаас аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын судалгааг авсан ба Ховд сум эзэмшиж байсан хуучин ногооны талбайн 4 га газраас 1 га газрыг, Өндөрхангай сум Хуучин сургуулийн суурь 0.07 га газрыг, Хуучин уурын зуух 0.11 га газрыг тус тус аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх боломжтой Сагил, Завхан, Давст зэрэг сумууд аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газар байхгүй, бусад сумуудаас аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын судалгааг ирүүлээгүй байна.Төмс, хүнсний ногоо, газар тариалангийн зориулалтаар өмчлүүлэх газрын судалгаа гаргаж 2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан боловч худалдаж өмчилж авахаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл хүсэлт одоогийн байдлаар ирүүлээгүй тул газар өмчлүүлээгүй байна. 2010 онд Тариалангийн зориулалтаар давуу эрхээр өмчлүүлэх 9 иргэн аж ахуйн, нэгж байгууллагад 7.2 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөгөөнд тусгаж ИТХ-аар батлуулсан.</p> <p>Ховд сум нь сумын засаг даргын 2010 оны 06-р сарын 07-ны 66 тоот захирамжаар аж ахуйн зориулалтаар 2 иргэнд 100м² газрыг худалдаж өмчлүүлсэн байна.</p>	30

2.4.6	5	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн хилийн цэсийг эргэлтийн цагийн солбилцлуудаар тодорхойлон баталгаажуулах ажлыг шат дараатай хийж, солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлнэ	Увс аймгийн Засаг захиргааны хилийн цэсийн зураглалын ажлыг 1959нд тогтоосон аймаг, сумын хилийн цэсийн протокол, 1973 оны аж ахуй дотоодын газар зохион байгуулалтын үндсэн материал, 1:100000 масштабтай байр зүйн зургийндэслэн А гсGIS 9,2 програм хангамждээр UTM ашиглан боловсруулж WGS 84 солбицолын тогтолцоонд шилжүүлсэн. 2009 онд Увс, Завхан аймгийн хил залгаа Цагаанхайрхан, Ургамал, Сонгино, Зүүнхангай сумдын хоорондох, Увс аймгийн Цагаанхайрхан, Өндөрхангай, Баруунтуруун, Зүүнхангай, Зүүнговь, Хяргас, Наранбулаг, Малчин, Өмнөговь, Өлгий сумдын хоорондох хилийн цэсий маргаантай, з өрүүтэй, ойлгомжгүй, тодорхойгүй байгаа асуудлыг тогтоох, маргааныг хоёр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, мэргэжилтнүүдийн бүрэлдхүүнтэйгээр, сумдын удирдлагууд, малчдын төлөөллийг байлцуулан 1959 онд тогтоосон аймаг, сумын хилийн цэсийн протокол, 1973 оны аж ахуй дотоодын газар зохион байгуулалтын үндсэн материал, 1:100000 масштабтай байр зүйн зургийг үндэслэн дээр нь хэмжилт хийж тодотгосон.	50
2.4.7	1	Шинэ хотхон, хорооллыг барих ажлын хүрээнд 37 мянган орон сууц барина	Увс аймаг 2009-2010 онд ТАХ-ийн 44 айлын орон сууцыг барьж, бага дунд орлоготой иргэдийн 50 айлын орон сууц, ТАХ-н 16 айлын орон сууцыг мөн ашиглалтанд оруулав. Уг орон сууцнуудыг 40 хувийн хямдралтай олгож 80 хүний амьдрах орчин нөхцөл дээшлэв. Ирэх дөрвөн жилд ТАХ-ийн 20х5 айлын, бага дунд орлоготой иргэдийн 30х3 айлын орон сууц барих бөгөөд нийт 266 айлын орон сууц барихаар төлөвлөсөн байна. Түүнээс энэ онд 66 айлын орон сууц ашиглалтанд орж, 20 айлын орон сууцны барилгын ажлын 70 хувь хийгдлээ. УИХ-ын гишүүн Б.Чойжилсүрэн 500 айлын орон сууц барихад газар, инженерийн шугам сүлжээ, техникийн нөхцлийг шийдүүлсэн.	90
2.4.11	1	Баруун, Хангайн, Төв, Зүүн болон Говийн бүсийн хөгжлийн хөтөлбөр боловсруулна	Баруун бүсийг 2006-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан билээ. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд үндэсний хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих арга зам” судалгаа хийж хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах ажилд ороод байна.	90
2.5.2	2	Баг бүрийг өрхийн амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн 1 сая-аас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй, эргэн төлөгдөх нөхцөл бүхий хөгжлийн сантай болгоно	Аймгийн хурлаар ИТХ-ын төлөөлөгч тус бүрт 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргаснаар тухайн баг, суманд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд түлхүү анхаарсан ажил боллоо. Орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ард иргэдийн хандиваар багийн сантай болох ажлыг зарим баг, сум санаачилга гаргах арга хэмжээ зохион байгуулж байна.	30
2.5.3	6	Аймгийн төвүүдийн дулаан хангамжийн байдалд судалгаа хийж шинэчлэлтийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулна	Эрчим хүчний газарт аймгийн дулааны станцын байдлыг судлах асуудлыг тавьсаны дагуу нарийн мэргэжлийн баг ирж ажиллан дүгнэлт гаргав. Үнэлгээ судалгаа хийж үзэхэд дулааны хангамжийн хувьд хангалтгүй төвшинд байсан бөгөөд зураг төсөв хийлгэх, техник эдийн засгийн үзүүлэлт боловсруулах ажлын шаардагдах хөрөнгийг улсын төсвөөс	100

			<p>шийдвэрлэхээр болж ,дулааны 2 дахь эх үүсвэр барих техник эдийн засгийн үзүүлэлт боловсруулан ЭБЭХЯ-ны ШУТ-ийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлууллаа. Зураг төсөв хийгдэж байна.</p> <p>2010 онд дулааны 2 дахь эх үүсвэрийн шугам шинээр барихад 750,0 сая төгрөгийн эх үүсвэр шийдвэрлээд байна.</p> <p>Дулааны станцын 2-р эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулж, ЭБЭХЯ-ны ШУТ-ийн зөвлөлөөр батлуулсан. Дулааны станц, шугамын ажлын зураг төсөв хийгдэж байна.</p>	
	7	<p>Аймгийн төвийн дулааны станц, дулаан хангамжийн системийн харъяалал, өмчийн хэлбэр, шугам сүлжээний хил заагийг тотоож дулаан хангамжийн зуух, тоног төхөөрөмжийг үе шаттай шинэлчлэх, халаалтын доголдолыг бүрэн арилгаж хэрэгцээний халуун усны системтэй болгон ард иргэдийн амьжиргааны таатай нөхцлийг бүрдүүлнэ</p>	<p>2009 онд Халаалт хэвийн ажиллах нөхцлийг хангах зорилгоор 33 сая төгрөгөөр бүх хэрэглэгчдийн дотор системийг угаах ажил хийгдсэн. Дулааны станцад засвар үйлчилгээнд зориулан Засгийн газраас 300.0 сая төгрөгийн хүүгүй зээл олгов. Орон нутгийн төсвөөс 90 гаруй сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Дулааны станц 2,3-р зуухны шинэчлэлийг хийж дуусгаад байна. Хотын дулааны шугам сүлжээ, орон сууцны хорооллын шугамыг төрийн мэдэлд 2009 онд авсан .Энэ онд Дулааны станц 2 зуух шинэчилж, “ССТ-Од”, “Дэвшил Увс” ХХК-ууд шинэ технологи бүхий тус бүр 11.5мвт-ын халаалтын зуух шинээр суурилуулав. Энэ ажилд 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулав.</p>	90
	8	<p>Ховд, Увс аймгийн төвд дулааны шинэ эх үүсвэр барих асуудлыг судалж шийдвэрлэнэ</p>	<p>Энэ онд зураг төсөв хийх, техник эдийн засгийн үзүүлэлт боловсруулах мэргэжлийн баг ажиллууллаа. Дулааны шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах тендерт “Мон-Энержи” ХХК шалгарч судалгааны ЭБЭХЯ-ны ШУТ-н зөвлөлөөр батлуулж зураг төсвийн зөвлөхийн тендерт шалгарч ажил эхлэх шатанд байна.</p> <p>Дулааны станцыг 2011 онд барьж эхэлнэ.</p>	70
2.5.4	1	<p>Улсын төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сан болон дотоод гадаадын хөрөнгө оруулалтаар цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл засвар шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ</p>	<p>Аймгийн хэмжээнд бүх сум цахилгааны шугамд бүрэн холбогдлоо.</p> <p>Мөн Завхан, Малчин, Бөхмөрөн сумдын 0.4 квт-ын шугамын ажлыг бүрэн ашиглалтанд оруулав. 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.</p>	100
2.5.6	3	<p>Орон нутгийн эрдэс түүхий эдийн нөөцөд тулгуурлан бүс нутгуудад бетон, төмөр бетон дуу чимээ дулаан тусгаарлах болон ханын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ</p>	<p>Цемент, хөөсөн болон хөнгөн блок, тоосго, боржин, гантиг чулууны үйлдвэр байгуулахаар тусгасан боловч ЗТБХБЯ-ны зүгээс арга хэмжээ авах талаар удааширалтай байна. Энд хөрөнгө, техник тоног төхөөрөмж шийдвэрлүүлэх талаар тодорхой санал тавиад байна.</p> <p>Өмнөговь суманд тоосгоны үйлдвэр байгуулахаар ЖДҮ-ийн сангаас 50 сая төгрөгийн зээл олгосон.</p>	30
5.3.4	2	<p>Төв орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг сайжруулж нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна</p>	<p>499,4 сая төгрөгний өртөг бүхий МХГ-ын шинэ байрыг 2009 ондашиглалтанд оруулж иж бүрэн тохижуулан ажиллах нөхцлийг бүрэн хангав.</p> <p>Тус байгууллага шинэ байртай болж интернет, дотоод сүлжээнд бүрэн холбогдон ажиллаж байна.</p> <p>Байцаагчдын нийгмийн баталгаа хангах болон сургалт хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Мөн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 5 байцаагчийг Удирдлагын академийн менежерийн сургалтанд, давхардсан тоогоор 51 байцаагчийг мэргэшил дээшлүүлэх урт богино хугацааны сургалтанд хамрууллаа. Мөн ажлын байранд долоо хоног тутам эрхзүйн сургалтыг зохион байгуулж хэвшлээ.</p> <p>Улсын байцаагчдынхаа нийгмийн асуудлыг</p>	100

			шийдвэрлэхэд зориулан 24 айлын орон сууц барихаар төлөвлөж газрыг нь авч, зураг төслийг нь бэлэн болгоод байна.	
	3	Хилийн боомтуудын мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн орон тоог нэмэгдүүлж, зайлшгүй шаардлагатай багаж, техник хэрэгслэлээр ханган ажлын болон ахуйн байртай болгоно	УМХГ-ын даргын 2008 оны 11 дүгээр сарын 10-ны 351 дүгээр тушаалаар Боршоо, Тэс боомтуудын мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын орон тоог 4 улсын байцаагчийн орон тоогоор нэмэгдүүлэн тогтоож өгсөн. Одоо аймгийн МХГ-ын Хилийн хяналтын хэлтэст 9 улсын байцаагч ажиллаж байна. Хилийн мэргэжлийн хяналтын албаны бүтэц, орон тоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ зайлшгүй шаардлагатай багаж, техник хэрэгслээр хангах ажлыг ээлж дараатай гүйцэтгэн ажиллаж байна. Тухайлбал: Хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг бэхжүүлэх хүрээнд тус хэлтэст иж бүрэн компьютер, принтер олгож, ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулав. Ажилтнуудыг боомт хооронд сэлгэн ажиллуулах тушаалуудыг гаргаж хэрэгжүүлж байна. Тэс суманд байрлах Шарсуурь боомтод 8x7.5 харьцаатай ажилтны амьдрах байрыг төсвийн тодотголоор буюу УМХГ-аас шилжүүлсэн хөрөнгөөр барьж ашиглалтанд орууллаа. Түүнчлэн АНУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй цөмийн материал, цацраг идэвхт бодисыг илрүүлэх орчин үеийн багаж төхөөрөмжийг суурилуулан ашиглалтад оруулж, боловсон хүчнийг сургаж бэлтгэх төслийн хүрээнд цацраг идэвхит бодисыг илрүүлэх иж бүрэн тоног төхөөрөмжийг Боршоо боомтод суурилуулах ажил хийгдэж дууссан бөгөөд одоо энэхүү тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хүчнийг бэлтгэх шаардлагатай байна.	50
2.5.10	1	“Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд газар тариалангийн техник технологийн парк шинэчлэх ажлыг хэрэгжүүлж өндөр хүчин чадалтай трактор 725, үр тарианы комбайн 550-ийг нийлүүлнэ	“Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд: Үр тарианы комбайн-5 ширхэг, өндөр хүчин чадал бүхий трактор дүүжин машин- 5 ширхэг, бага оврын трактор- 20 ширхэг, дунд хүчин чадлын трактор – 2 ширхэг, 5 га- ийн услалтын систем- 5ш, бага болон дунд хүчин чадлын тэжээлийн үйдвэр 3ш –ийг тус тус авах захиалгаа ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Баруунтуруун суманд газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалттай 1.2 тэрбум төгрөгний өртөг бүхий 38ш техник тоног төхөөрөмж нийлүүлэгдэж үйл ажиллагаа явуулж эхлээд байна.	90
3.2	1	Агаарын бохирдлыг бууруулах, чанарыг хангах эрх зүйн орчныг шинэчилж агаарын бохирдлыг бууруулах талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ	Аймгийн хэмжээнд УЦУОШАлбанд дээр агаарын бохирдолыг тогтмол хянаж байгаа болно. 2010 онд Аймгийн Засаг даргын “Аймгийн агаарын чанарын салбар зөвлөлийг байгуулах тухай” 284 тоот захирамж гарган салбар зөвлөлийг ажиллуулж эхлээд байна.	30
	4	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд агаарт гаргах тоосонцорын хаягдлыг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлнэ	Томоохон хэмжээний үйлдвэрлэл байхгүй учир тоосонцорын нөлөөлөл байхгүй	50

3.3	2	Томоохон хот суурин газрын цэвэрлэх байгууламжинд техник технологийн шинэчлэл хийж ашиглалтыг сайжруулан, стандартын шаардлага хангуулна	Улаангомын одоогийн цэвэрлэх байгууламж шаардлагын түвшинд ажиллахгүй байгаа учир цаашид шинээр барих ажлын зураг, төсөв боловсруулалтын шатанд байна.	10
3.4	2	Бүх аймгуудын хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	2002 оны аймгийн ИТХ-ын 7-р хуралдааны 10-р сарын 8-ны 7/1 дугаар тогтоолоор баталсан “Цэвэр орчин” хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хог хаягдал, орчны бохирдолыг бууруулах чиглэлээр мөрдүүлэн ажиллаж байгаагаас гадна бүх сумдад хог хаягдлын хөтөлбөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. “Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай” хууль болон Засгийн газрын 2007 оны 18-р тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 30-р тогтоолоор аймгийн хэмжээнд дагаж мөрдөх хогны төлбөрийн нормативийг батлуулан хэрэгжүүлэх ажлыг хийж эхлээд байна. 2010 оны 4-р сарын 28-ний өдрийн 211 тоот захирамжаар “Хог хаягдал цуглуулах, булах, тээвэрлэх, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны болон байгаль орчныг бохирдолоос хамгаалах талаар сум, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам” гарган мөрдүүлж эхлээд байна.	30
	4	Бүсийн тулгуур төв хотуудад хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах, томоохон хот суурин газрын хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулж, хог хаягдлыг булшлах ландфиллийн аргыг нэвтрүүлнэ	2008 онд улсын төвлөрсөн төсвөөс 135.0 төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн хогийг ландфиллийн аргаар булшлаж хашаажуулах ажлыг хийснээс гадна хот тохижилт үйлчилгээний газарт хог ачиж буулгах зориулалт бүхий трактор, өөрөө буулгагч 20 тн-ны даацтай ачааны машин, хог дахин боловсруулах жижиг үйлдвэр байгуулан ажлуулж эхлээд байна	30
3.5	2	Гол мөрний сав газруудын зөвлөлийг байгуулан ажиллуулж сав газрын усны менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	Гол, мөрний сав газрын зөвлөлийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2006 оны 88 –р тогтоолоор батлан хэрэгжүүлэх ажлыг хийж байгаа бөгөөд аймаг хоорондын гол мөрөн болох Ховд, Завхан голын сав газрын зөвлөлд орж ажиллах хүмүүсийн нэрсийг БОАЖЯ-нд хүргүүлж сайдын 59 тоот тушаалаар Ховд голын сав газрын зөвлөл байгуулж 4 удаагийн сургалт семинар зохион байгуулагдахад аймгийн төлөөлөл оролцсон болно. Мөн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 91 тоот тогтоолоор Завхан голын сав газрын зөвлөлийг батлуулсан болно. 2010 онд Усны тухай хуулийн 19 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор бүх сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор голуудын сав газрын зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Оны эхэнд тус тогтоолуудаас хоёроос дээш сумын нутаг дамжин урсдаг Баруунтуруун, Хангилцаг, Зүүнтуруун, Хөндлөн, Намир, Тээл, Хархираа голуудын сав газрын зөвлөлийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар оруулан хэлэлцүүлж 20 дугаар тогтоол гарган 5 гол мөрний сав газрын зөвлөл байгуулж дарга нарийн бичгийн дарга нарт гарын авлага материал хүргүүлж ажиллав. Мөн хуралдаанаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 332 тоот тушаалын дагуу Увс нуур-Тэсийн голын сав газрын зөвлөлд оруулах гишүүдийн санал батлуулж 19 дугаар тогтоол гарган Усны газарт хүргүүлж мөн өнгөрсөн жил гаргасан Завхан голын сав газрын тогтоолыг шинэчлэн 41 дугаар тогтоол гаргаж сав газрын зөвлөлд ажиллах	70

			<p>хүмүүсийн анкетын хамт хүргүүлээ. Ховд голын сав газрын зөвлөлийн семинарт 2 удаа оролцож Ховд голын сав газрын усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах менежмент төлөвлөгөөг эхний хувилбараар баталлаа. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа сав газрын зөвлөлийн гишүүдийн чадавхийг дээшлүүлэх мэдээллэл хүргэх , усны нөөцийн нэгдсэн менежментийн тухай ойлголт өгөх зорилгоор Алтай-Соёны төслийн дэмжлэгтэйгээр Түргэн, Сагил, Бөхмөрөн, Ховд, Улаангом, Тариалан суманд шинээр батлагдсан сав газрын зөвлөлийн гишүүд, байгаль хамгаалах нөхөрлөлийн ус ашиглагч нарыг оролцуулсан 2 өдрийн сургалт хийж сургалтанд 30 орчим хүн хамрагдлаа.</p> <p>Ховд голын сав газрын зөвлөлийн ээлжит 3-р хуралдаан Увс аймагт хуралдаж Тээл,Хархираа,Хөндлөн, Нарийн,Баруунтуруун, Намир голын сав газрын зөвлөлийн дарга нар оролцов. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулагдсан 5 голуудын сав газрын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар10 хүн голуудын сав газрын зөвлөлийн анхдугаар чуулганд Улаанбаатар хотод оролцлоо.</p>	
	10	Усан сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоож дэглэмийг мөрдүүлнэ	<p>Шинэчлэн гарсан журмыг хэрэгжүүлэх ажлыг хийж эхлээд байна.БОАЖСайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг удирамжийн дагуу тус аймгийн нутаг дэвсгэрт усан сан бүхий газрын ус хангамжийн эх үүсвэрийн болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоох ажлыг аймгийн Байгаль орчны мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйтгэсэн болно.</p> <p>2010 онд БОАЖ-ын сайдын 370 тоот тушаалын дагуу усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс тогтоох ажлын хэсэг Увс аймагт ажиллаж 4 хэсэг болон бүх суманд ажиллаж журмын дагуу 177 гол горхи,113 нуур цөөрөм, 462 булаг,28 рашаанд энгийн хамгаалалтын бүс тогтоолоо.</p>	50
3.6	1	Гадаргуугийн урсац, хур тунадасны усыг хуримтлуулах замаар усан болон хөв цөөрөм байгуулж бэлчээр хадлан, тариалангийн талбайг усжуулах,ногоон байгууламжийн усалгаанд ашиглах аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжинэ	Сагил сумын Ёлын аманд ус хуримтлуулах далангийн зураглал хийгдсэн. Ажил нь одоогоор эхлээгүй байна.Түргэн сумын нутаг Хээр морьт гэдэг газарт 7,1 сая төгрөгийн өртөгтэй 10 га талбай услах хүчин чадал бүхий хөв барьж ашиглалтанд оруулсан	50
	2	Ойжуулах, мод, бут, сөөг, загийг үрээр тарималжуулах, ногоон байгууламжийг эрчимжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгжийн төсөл арга хэмжээг санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжинэ	<p>2009 онд 238 га талбайд ойжуулалт, 15 га–д Ногоон хэрмийн туслах зурвас төгөл байгуулах ажлын мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэлээ. Ойжуулалтын ажлыг Зүүнговь сумын Харбураа, Улаангом сумын Цагаан бураа, Тэрэм хад, Өндөрхангай сумын Могойн бэлчир, Сагил сумын Далт зэрэг газруудад хийсэн ба Ногоон хэрмийн туслах зурвасыг Наранбулаг, Завхан, Улаангом зэрэг сумдад , 2010 онд 320 га-д ойжуулалт, 10 га-д ногоон хэрэмийн туслах зурвас байгуулах ажлыг Сагил Наранбулаг , Улаангом, Өндөрхангай , Малчин, Тэс сумдад ойжуулалт, туслах зурвасын ажлыг тус тус хийж гүйцэтгэлээ</p> <p>Аймгийн Засаг даргын 2006 оны 356 тоот захирамжаар баталсан “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ын дагуу мод тарьж ургуулсан иргэдийн материалыг бүрдүүлэн төрийн сангийн хэлтэст</p>	90

			хүргүүлсэн бөгөөд 2009 оны намар тарьсан модны амьдралтын хувийг тогтоон, санхүүжилтийн гэрээний дагуу иргэн, байгууллагад 11–н сая төгрөгний урамшууллыг Ойн газраас олгосноос гадна 2010 оны гэрээний материалуудыг хүргүүлээд байна.	
3.7	1	Бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэн говь хээрийн бүсийн усны нөөцийн судалгаа явуулж уст цэг гаргах дүгнэлт гарган баг бүрд нар салхины эрчим хүчээр ажиллах тус бүр нэг худаг гаргана	Байгаль цаг уурын нөлөөлөл, мал сүргийн өсөлт, сүргийн бүтэц, хур тунадасны хэмжээ, усан хангамжийн хүрэлцээ зэргээс шалтгаалж бэлчээрийн даац багтаамж нэмэгдэж аймгийн хэмжээнд бэлчээрийн 40 гаруй хувь талхлагдсан бөгөөд сум бүрт харилцан адилгүй байна. Тогтвортой амьжиргаа төслөөр “ Бэлчээрийн ургацыг тогтоох аргачлал “ сэдэвт сургалтанд ХХАА-н мэргэжилтэн 25 хүнийг 2 өдрийн сургалтанд хамруулсан. “ Тогтвортой амьжиргаа – II” төслөөр бүх сумдын бэлчээр ашиглалтын зургийг шинээр хийсэн .Алтай соёны төслөөр Ховд, Сагил, Улаангом,Бөхмөрөн, Түргэн сумдын малчид, малчдын бүлэг,нөхөрлөлийн төлөөлөл, ХХАА-н асуудал хариуцсан мэргэжилтэн нарт “ Бэлчээрийн менежмент “ сэдэвт сургалт зохион байгуулсан. Нар салхины эрчим хүчээр ажиллах худаг гаргах ажил хийгдэж эхлээгүй байна.	30
3.9	1	“Атрын 3 дахь аян”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг урамшуулах дэмжих бодлого хэрэгжүүлнэ	Газар тариалан эрхэлж буй иргэдэд ойн зурвас байгуулах зориулалтаар төрөл бүрийн жимс жимсгэнэ,чацаргана, чимэглэлийн модны суулгацыг хямдарсан үнээр олгосон. Суулгац үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдааг 2009 онд Улаангом суманд зохион байгуулж, мод үржүүлгийн талаар сургалт зохион байгуулсан. Өмнөговь, Малчин, Улаангом, Тариалан сумдад төрөл бүрийн модны суулгац тариалж, тариалангийн талбайд ойн зурвас байгуулж байна. Газар тариалан, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжинд шинээр гаргаж байгаа болон инженерийн хийцтэй гүн өрмийн худаг түшиглэн газар тариалан эрхэлж ойн зурвас байгуулах тухай уриалга гаргасан. 2010 онд “Арвижих-Увс” ойн зурваст улиас тариалсан. Жимс, жимсгэнэ, чацарганы тариалан эрхлэгчдэд ойн зурваст шар хуайлс, хайлаас, бургас, саваа мод тариалах чиглэлийн төслүүдэд ЖДҮД-ийн сангаас 15.5 сая төгрөгний зээлийн дэмжлэг үзүүллээ.	70
3.14	2	Орон нутгаас тусгай хамгаалалтад авах газар нутгийн шалгуур үзүүлэлт, үндэслэлийг шинэчлэн тогтоож, бүртгэл тооцоог Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээнд хамруулна	Орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамруулах ажил аймгийн хэмжээнд боловсруулах шатандаа явагдаж байна.2010 онд Орон нутгийн тусгай хэрэгцээний газрын мэдээллийг шинэчилсэн байдлаар нэгтгэн авахаар сумдад үүрэг чиглэл өгч албан тоот хүргүүлснээр аймгийн 13 сумын 24 газрын 441.4 мянган га-г орон нутгийн тусгай хамгаалтанд авсан материалыг хүлээн авч ARC –GIS программ дээр мэдээллийг оруулж зураглал хийв.	30
	8	Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдалд үнэлгээ хийж дүгнэлт гарган тухайн газар нутгийн онцлог, нөөц даацад тохируулан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах арга зүйг боловсруулан хэрэгжүүлнэ	Боловсруулах шатандаа явагдаж байна	10

3.15	9	Хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэх, хянах үйл ажиллагааг орчин үеийн технологи ашиглан боловсронгуй болгож орон нутгийн ойн байгууллага болон нутгийн иргэдийн оролцоонд түшиглэн тэмцэнэ	Хууль бусаар мод бэлтгэх үйл ажиллагаатай тэмцэх чиглэлээр Цагдаагийн байгууллагатай хамтран аймгийн байгаль орчны чиглэлийн байгууллагууд энэ төрлийн гэмт хэрэг таслан зогсоох зорилгоор хавар, намрын улиралд “Нүүдэл I, II “ гэсэн тусгай арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан явуулж байна. Энэ ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2009 оны 249 дугаар захирамжаар Байгаль орчин аялал жуулчлалын газрын дэргэд Ойн асуудал хариуцсан Ойн нэгжийг байгуулж ажиллуулж эхэлснээс гадна ой бүхий сумдад ойг гэрээгээр эзэмшүүлэн хамгаалах зорилгоор 7 нөхөрлөл байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Ханх өхийн нуруу болон Алтайн салбар уулсын ойн ангийг Өндөрхангай, Түргэн суманд аймгийн Засаг даргын 2010 оны А/301 дугаар захирамжаар байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлэх бэлтгэл ажлыг хийж байна	50
3.16	4	Ховордсон ан амьтныг хамгаалах ажлыг сайжруулж, мазаалай баавгай, хавтгай тэмээ, бадгана хүдэр, монгол бөхөн, буган цаа, голын халиу, хар мөрний хилим зэрэг нэн ховор амьтдыг идээшил нутагт нь өсгөн үржүүлэх, тэдгээрийн генийн сан хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглана	Ховор 7 зүйлийн амьтан \аргаль, янгир, хар сүүлт зээр, халиун буга, зэгсний гахай, хадны суусар, эрээн хүрнэ\ байдаг. Эдгээр ан амьтны амьдрах орчныг хамгаалах чиглэлээр тухайн амьтны байршил нутаг дэвсгэрийг улсын болон орон нутгийн хамгаалалттай газрын ангилалд хамруулж хамгаалалтыг сайжруулснаас гадна ан амьтны байршил бүхий нутагт амьдарч байгаа иргэдээр хамгаалуулах зорилгоор агнуурын менежментийн чиглэлийн 17 нөхөрлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Цагаан шувуут, Баянзүрхийн нурууны Баданга хүдрийн тархац байршил нөөцийн судалгаа Алтай соёны төслийн санхүүжилтээр “Монголын х үдэр хамгаалах сан”-тай хамтра батлагдсан аргаз үй, удирдамж, төлөвлөгөөний дагуу Цагаан шувуут уулс, Баянзүрхийн нурууд 2006 -2007 онуудад давтан хийгдэж Увс аймгийн Сагил сумын нутаг Цагаан шувуут уулын системийн Баянзүрх уулын Их Хөсөрлөг, Бага Хөсөрлөгөөс гадна Нарийн дэл, Чигэрсэнд баданга хүдэр идээшин нутаглаж байгааг шинээр тогтоолоо. Цагаан шувуутын уулсын системийн Баянзүрхийн Их хөсөрлөг, Бага Хөсөрлөг, Нарийн дэл, Чигэрсэн ууланд нийтдээ 15 баданга хүдэр идээшин нутаглаж байна. Нарийн дэл уул баданга х үдрийг хамгаалан гаршуулж үржүүлэх экологийн боломжтой нутаг хэмээн урьдчилан үзэв. Цаашид энэ нутгийн экологийн нөхцөл хүдрийн идэш тэжээлийн нөөцийг нарийвчлан тусгайлан судлан тогтоосны үндсэн дээр хүдэр гаршуулан үржүүлэх газрыг товлож энэ талаар тал бүрийн ул суурьтай судалгааны ажлуудыг хийж байна.	50
3.17	3	Газрын нэгдмэл сангийн тайлангийн өгөгдлүүдийг боловсронгуй болгох, түүнд газар ангилалын шилжилт, хөдөлгөөнийг байнга тусгах, байгаль орчны даац чадавхид нийцүүлсэн газар зохион байгуулалтыг урт хугацааны менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	Интернетийн болон сүлжээний орчинд хэрхэн ажиллах талаар, Team viewer программ суулгах болон хэрэглээнд ашиглах, ГТ-1, ГТ-4, ГТ-6, ГТ-7 тайлангийн тоон үзүүлэлтийг бодиттой болгох, жижүүрийн зурагт үзүүлэх, зураг үйлдэх, тэдгээрийн таних тэмдэглэгээний талаар танилцуулга бэлтгэн мэдээлэл хийж, G-mobile-ийн модем олгогдсон сумдын даамлуудын модемыг ашиглах сургалтыг зүүн 6 сумын даамалуудыг хамруулж техник хэрэгслийн ашиглалт хамгаалалтын талаар болон хэрхэн зүй зохистой ашиглах, интернетийн сүлжээ бүхий сумдуудыг хэрхэн зөв холбогдох, зураг хэрхэн хэвлэх, GPS-ээр авсан координатаа зурагт хэрхэн буулгах, бэлчээрийн зураглалын WEST-1 программыг хэрхэн ашиглах талаар сургалт хийж одоо интернетийн	50

			<p>сүлжээгээр мэдээлэлээ өгч байгаа болно.</p> <p>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг жил бүр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гарган мөрдөн ажиллаж байна.</p> <p>Аймгийн “ Газрын талаар баримтлах бодлого” боловсруулан ИТХ-ын хуралдааны 2009 оны 12-р сарын 25-ны өдрийн 4/02 тоот тогтоолоор батлуулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.</p>	
	5	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр дамжуулан байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг жил бүр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахдаа байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хийж байгаа болно	50
3.18	2	“Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлнэ	<p>2008 онд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар “Увс аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр”-ийг шинэчлэн батлан гаргаж хэрэгжүүлэх ажлыг эхлээд байна.</p> <p>Одоогийн байдлаар аймагт жуулчны бааз 3, амралт сувиллын газар 2, зочид буудал 3, үйлчилгээний төв 5 тус тус ажиллаж байна.</p>	50
	3	“Аялал маркетингийн төлөвлөгөө” жуулчлалын стратеги боловсруулж Монгол улсыг нэгдсэн бодлоготойгоор гадаадад сурталчлах ажлыг зохион байгуулна	Баруун бүсийн хувьд хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор баруун 3 аймаг, Горно-Алтайск, Тува улсын холбогдох албадын төлөөлөгчид 2010 онд Баян-Өлгий аймгийн Өлгий хот, Горно-Алтайск хотуудад зөвлөлдөх уулзалт зохион байгуулж санамж бичгүүдийг баталсан болно.	50
	4	Аялал жуулчлалын мэдээллийн сан бий болгож салбарын статистик бүртгэлийг сайжруулна	Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн санг БОАЖГ-т төвлөрүүлэн ажиллуулж эхлээд байна. Аймагт байгаа жуулчны бааз, гэр бааз, амралт сувилалын газрууд, зочид буудал, үйлчилгээний төвүүдийн болон дотоод, гадаад жуулчдын мэдээлэл, тоо баримтыг шинээр тусгаж, аялал жуулчлалын ерөнхий мэдээллийг солилцдог болсон.	70
	5	Жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулна	Одоогоор ажиллаж байгаа жуулчны баазуудад жуулчин хүлээж авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын салбарт ажиллагсадын боловсролыг дээшлүүлэх зэрэгт хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж эхлүүлээд байна. 2008 онд зочид буудал, зоогийн газрын менежер, үйлчлэгч нарт, 2009 онд газарчин, хөтөч нарын, 2010 онд тогооч нарын сургалт зохион байгуулж, оролцогчдод сертификат олгосон.	50

	6	Аялал жуулчлалын томоохон цогцолбор барьж байгуулна	“Баруун бүсийн аялал жуулчлал” хөтөлбөрийн хүрээнд бүсийн нутгийн хэмжээнд аялал жуулчлалын цогцолбор барих ажлыг хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан болно. Мөн хил дамнасан аяллыг хөгжүүлэх нэгдсэн маршрутыг тохиролцож, Горно-Алтай, Тува талаас жуулчин солилцох бэлтгэлийг хангаж байна.	10
	7	Түүх соёлын болон адал явдалт, тусгай сонирхлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах ажлын дэмжинэ	Түргэн сумын нутагир “Жэ” жуулчны баазад түшиглэн, “ОТ-тур” ХХКомпани хүүхдийн мини наадам, ардын язгуур урлагийн баярыг 3 жил дараалан хийж, энэ жилээс МАЖХ-ны эвент арга хэмжээний төлөвлөгөөнд албан ёсоор оруулсан. Хархираа ууланд Монгол хүн авирсаны 50 жилийн ойг тохиолдуулан “Хархираа альпинад-2009” авиралт аяллыг зохион байгуулж 10 –аад аймгийн 53 жуулчин оролцсон авиралт амжилттай боллоо. Мөн Зүүнхангай, Зүүнговь, Өмнөговь сумдад рашаан усны, Бөхмөрөн, Ховд, Сагил, Улаангом, Түргэн сумдад НИТАЖ-ын сүлжээний нөхөрлөлүүд үйл ажиллагаа эрхлэж байна.	70
3.19	2	Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглахтай холбогдуулан аймаг сумын Засаг даргын үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ	Увс аймгийн байгаль орчныг хамгаалах, нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх хаталбөрийг 2007 онд аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх ажлыг хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасны дагуу зохион байгуулан хийж байна. Аймгийн хэмжээгээр байгаль хамгаалах иргэдийн 24 нөхөрлөл байгуулагдсанаас 7 нь ойн санг хамгаалах чиглэлийн, үлдсэн нь байгалийн баялаг, ан амьтныг хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. 2010 онд шинээр Цагаанхайрхан суманд 2, Өндөрхангай суманд 1, Малчин суманд 1 ойн нөхөрлөл шинээр байгуулагдсан. Байгуулагдсан нөхөрлөлүүдийн гишүүдийг сумын буюу аймгийн түвшинд туршлагыг сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулж чуулга уулзалтыг бүсчлэн ДБХС-ын МдХГ-ын Увс аймгийн нэгж, АСБТЗАИОХТөслийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан нь үр дүнтэй арга хэмжээ болсон. Уулзалт өдөрлөгт Увс аймагт байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн газрын ажилтан мэргэжилтнүүд, нөхөрлөл, малчдын төлөөлөл хүрэлцэн ирж оролцлоо. Мөн Увс аймагт хэрэгжиж үйл ажиллагаагаа явуулж буй төсөл хөтөлбөрийн ажилтнуудтай хамтран нөхөрлөлийн цаашид ажиллах зарчмын талаар тодорхой ойлголтод хүрч, нөхөрлөлийн үйл ажиллагаанд мониторинг хийх ,бүх нөхөрлөлүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, заавар зөвлөгөө өгөн ажиллаа. Улсын төсвийн санхүүжилтээр Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сумын ойн санг эзэмшин хамгаалж байгаа Давшилт Увс, Хорин булаг, Баянханхөхий, Буган толгой, Ханхөхийн цуурай зэрэг нөхөрлөлийн 11000 га талбайд ой зохион байгуулалтын ажлыг хийлгэж, нөөцийг тогтоолгосон ба материалыг хүлээн авч нөхөрлөлүүдэд гардуулаад байна.	50

3	Ашигт малтмал олборлосон эдэлбэр газрыг нөхөн сэргээх стандартыг баримтлан хяналт хариуцлагын механизмыг боловсронгуй болгоно	Тус аймагт нүүрс болон алтны орд ашиглаж байгаа уурхайнууд нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэх ажлыг МХГазар хяналтыг байнга тавьж ажиллаж байгаа болно. 2010 оны 6-р сарын 4-6-ны хооронд “Хариуцлагатай уул уурхай-нөхөн сэргээлт” семинарыг зохион байгуулж Уул уурхайн олборлолт ихтэй Тариалан, Бөхмөрөн, Өмнөговь, Түргэн, Сагил сумуудын Засаг дарга нар, байгаль орчны хяналтын улсын байцаагчид, байгаль хамгаалах нөхөрлөлийн төлөөлөл оролцсон 47 хүний семинарыг хийж Дацан трейд ХХК-ны алтны уурхай дээр нөхөн сэргээлт хийх үзүүлэх сургууль хийлээ.	30
4	Байгаль орчинд сөргөөр нөлөө үзүүлж байгаа үйлдвэр үйлчилгээнд байгаль орчны болон олон нийтийн хяналтыг сайжруулна.	Манай аймгийн хувьд байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйлдвэр байхгүй хэдий ч мал нядлах цех, тоосгоны жижиг үйлдвэр, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн захыг хотын гадна байршуулах шийдвэр гарган мөрдөн ажиллаж байна.	50
4.5.7	3	Орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэн нутгийн өмчийн тухай бие даасан хуультай болгож эрх зүйн орчныг боловсронгуй болгоно	30
4.1.3	2	Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг нийтэлдэг”Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газраар дамжуулан засаг захиргааны анхан дунд шатны нэгж байгууллага бүрт хүргэх арга хэмжээ авна	50
5	Эрх зүйн туслалцааны төвийг 21 аймаг, 9 дүүрэгт НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн туслалцаатайгаар байгуулж үйлчилгээний хүрээ өргөжүүлнэ	2007 онд Аймгийн ЗДТГ-т Эрхзүйн туслалцааны төв байгуулж тамгын газраас 1.2 сая төгрөг, 2008 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төслийн хүрээнд ХЗДХЯамнаас 4.340.110.0 төгрөг нийт 5.540.110.0 төгрөний эд тавилгатай болгож, 2 өрөөг иж бүрэн тохижуулсан. 2008 оны 8 дугаар сарын 1-нээс эрхзүйн туслалцааны төвд өмгөөлөгч ажиллаж иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон төлбрийн чадваргүй иргэдийг шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд өмгөөлөх үйл ажиллагаа явуулж байна. Төв нь иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх зөвлөгөө өгөх, тэднийг эрх зүйн лавлагаа мэдээлэлээр хангах, сургалт сурталчилгаа явуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөлийн туслалцаа үзүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэж, мэдээ тайлангаа холбогдох газруудад хүргүүлж ажиллаж байна. Төвөөр үйлчлүүлэх иргэдийн тоо тогтмол өсөх хандлагатай байгаа ба иргэдийн сэтгэл ханамж өндөр байна.Сумуудад өрийн мэдээлэл сургалт, сурталчилгааны буланг ЗДТГ -ын даргын өрөө эсвэл хурлын танхим, үүдэнд эрх зүйн сургалт	100

			сурталчилгааны холбогдох материал, самбарыг байршуулж, иргэдэд эрх зүйн гар болон цахим сангаас лавлагаа өгч үйлчилж байна. 2010 онд төвөөс 108 иргэнд эрх зүйн лавлагаа, 584 иргэнд эрх зүйн зөвлөгөө, 73 иргэнд өмгөөллийн туслалцаа үзүүлж ажиллаа.	
4.2.10	3	Согтууруулах ундааны үйлдвэрлэл үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж гаргасан санал дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авна	Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймгийн ИТХТ-ийн 2009 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 38 дугаар тогтоолоор “Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох журам” 2009 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 157 дугаар тогтоолоор “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих дэд хөтөлбөр”-ийг батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих комисс жил бүр дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд аттестатчилал хийж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэдэг. 2009 оны сүүлээр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн үйл ажиллагаанд аттестатчилал явуулсанаар 117 цэгийн үйл ажиллагааг хүчингүй болгосон ба одоогийн байдлаар хөдөөгийн сумдад тусгай зөвшөөрөлтэй цэг 73, аймгийн төв Улаангом суманд тусгай зөвшөөрөлтэй үйлдвэр 1, худалдааны цэг 81, үйлчилгээний цэг 15 байна. Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах цэгүүдэд айгийн Засаг даргын тамгын газар хамтран 4 удаагийн үзлэг шалгалт хийлээ. Улсын мэргэжлийн хяналтын ээлжилт шалгалт тус аймагт хийгдэх үеээр архи согтууруулах унаа үйлдвэрлэх болон үйлчлэх байгууллага, цэгүүдэд шалгалт хийж хуулийн зөрчил арилгах талаар үүрэг даалгавар өгч ажилласан. Хууль зүй дотоод хэргийн сайдын баталсан 2010 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, сурталчлах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулж байгаа газруудад хийх шалгалтын удирдамж”-ийн дагуу Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтэс, Цагдаагийн Газар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтсийн бүрэлдэхүүнтэйгээр аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаа үйлдвэрлэгч, худалдаа, үйлчилгээний цэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гарган зөвлөмж өгч хариуцлага тооцож ажиллалаа. Мэргэжлийн хяналтын газраас энэ онд бүх сумдаар явж согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажилсан. Иймд энэ байдалд дүгнэлт хийж 2010.10.15-ны өдрийн Аймгийн ИТХ-ын V хуралдаанаар аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн даргын “Гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдал, архидан согтуурахтай тэмцэх, ажлын явц, цаашид авах арга хэмжээ” сэдэвт илтгэлийг гэмт хэрэг зөрчлийн өнөөгийн байдал түүнд хийх дүн шинжилгээ, хилийн зөрчил, хил дамнан мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих дэд хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн 3 дэд сэдвийн дор тавьж аймгийн Засаг дарга, сумдын ИТХ-ын дарга, Засаг	90

			дарга нар, аан байгууллагын дарга нар тус бүрт даалгасан 5-10 үүрэг заалт бүхий тогтоолыг батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. 2010 оны 11 сард бүх сумдад архидаг согтуурахаас сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, үр дүнд хяналт шинжилгээ хийж, сумдын ажлыг дүгнэх нэг үзүүлэлт болгож гаргалаа.	
4.2.12	3	Ялтны мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулж ялтныг ажлын байнгын байраар хангах асуудлыг шийдвэрлэнэ	Манай аймагт хорих анги байхгүй.	100
4.3.3	1	Улсын хил хамгаалах үүргийн 50 хүртэл хувийг гэрээт хилчнээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авна	Аймгийн Хил хамгаалахад туслах хүчний зөвлөлийг шинэчлэн, төлөвлөгөөгөө тодотгон ажиллаж байна. Сумдын зөвлөлийг сумдын Засаг даргын захирамжаар байгуулан нутаг дэвсгэрт байрлаж байгаа ХЦ-ийн заставтай хамтран ажиллаж байна. Аймагт байгаа хилийн 2 цэргийн ангид 23 гэрээт хилчин ажиллаж байна.	50
4.5.4	3	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулна	Монгол Улсын Их Хурлын 2002 оны 13 дугаар тогтоолоор батласан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг баримтлан Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул ажлын байранд сонгон шалгаруулалт зарлан зохион байгуулж байна. 2009 онд Сагил, Өлгий, Цагаанхайрхан сумын Засаг даргын тамгын газрын дарга, Наранбулаг, Хяргас сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарын бичгийн даргын ажлын байранд сонгон шалгаруулалт зарлан зохион байгуулж явууллаа. Энэхүү журам одоогоор шинэчлэгдээгүй байна.	50
	4	Төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулан сургаж чадавхийг бэхжүүлнэ	Төрийн албанд ажиллаж байгаа төсвийн ерөнхий менежерүүдийн Манлайлал- Менежментийн ур чадварыг дээшлүүлэх сургалтанд сумын ЗДТГ-ын дарга, сургуулийн захирал, соёлын төв, хүн эмнэлэг, цэцэрлэгийн эрхлэгч, аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагийн дарга нарыг оролцуулан зохион байгууллаа. Төрийн албан хаагчдын мэргэшил ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинарыг жил бүр тогтмол зохион байгуулан 70-90 удаагийн сургалт семинараар давхардсан тоогоор 1600 гаруй төрийн албан хаагч, Удирдлагын академийн урт богино хугацааны сургалт, гадаад улс орнуудад туршлага судлуулах дахин мэргэшүүлэх сургалтанд 5-10 хүнийг хамруулж байна. Төсвийн ерөнхий менежерүүдийн Манлайлах, менежментийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 8 удаа зохион байгуулж төсвийн ерөнхий менежер 165 хүнийг хамрууллаа.	100
	5	Төсвийн байгууллагын тогтолцоо бүтцэд судалгаа хийсний үндсэн дээр тэдгээрийн үйл ажиллагааны уялдааг хангах, иргэдэд үзүүлэх төрийн суурь үйлчилгээний чанар	Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын дэргэд Шүүх шинжилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Тээвэр авто замын газрыг шинээр байгуулан, ГХБХБГ, БОАЖГ-ыг өргөжүүлэн нэгтгэж зохион байгуулалт хийлээ. Төсвийн байгууллагын тогтолцоо бүтцийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа авах ажил	70

		хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр боловсронгуй болгох арга хэмжээ авна	хийгдэх шатанд байна. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг чанар хүртээмжтэй болгох зорилгоор нээлттэй хаалганы өдрийг тусгай графикаар баг, сум, агентлаг, албан байгууллагын түвшинд зохион байгуулагдаж байна. Мөн үйлчилгээний ажлыг хөнгөн шуурхай байлгах үүднээс аймгийн ЗДТГазарт нээлттэй утас ажиллуулж байна.	
4.5.5	1	Төрийн захиргааны төв болон орон нутгийн бүх шатны байгууллагын үйл ажиллагааны стратеги зохион байгуулалтын бүтцийг шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлэх замаар ажил үүргийн давхардал хийдэгдлийг арилгах төсвийн зардал хэмнэх арга хэмжээ авна	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоосон Монгол улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67-р тогтоолын дагуу удирдлагын бүрэлдхүүн, 5 хэлтэс, 2 тасаг, Цэргийн штаб гэсэн зохион байгуулалттай 41 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Сумын ЗДТГазар, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн бүтэц, орон тоог үзүүлж буй төрийн үйлчилгээ, иргэдийн тоо хэмжээг харгалзан 2009 оноос эхлэн шинэчлэн тогтоон өгч мөрдөж байна. Засаг даргын тамгын газрын стратеги хөгжлийн хөтөлбөр, эрхэм зорилгыг хамт олноор хэлэлцүүлж шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллаж байна.	70
	2	Төрийн албан тушаал (ажлын байр) –ын чиг үүргийн шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хүлээх үүрэг хариуцлагыг нь тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан баталж мөрдүүлнэ	Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дугаар тогтоолоор батлагдсан стандартыг баримтлан 2005 оноос эхлэн аймаг, сумын төрийн бүх албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төсвийн байгууллагуудын ажилтаны ажлын байрны тодорхойлолтыг 2010 оны 1-р улиралд шинэчлэн боловсруулж ажил үүргийн давхардлыг арилган ажиллаж байна.	100
	3	Гадаад дотоод орчны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төсвийн байгууллага бүрийг өөрчлөн хөгжүүлэх замаар байгууллагын шинэ соёлыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл баталгааг хангах арга хэмжээ авна	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг төсвийн бус байгууллагуудад 2009 онд шинэчлэн боловсруулж, батлан мөрдөн ажиллаж байна. Гадаад дотоодын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төсвийн байгууллага бүрийг өөрчлөн хөгжүүлэх замаар байгууллагын шинэ соёлыг төлөвшүүлэх ажлыг эхлэн хэрэгжүүлж байна. Төсвийн ерөнхий менежерийн манлайлал менежментийг сайжруулах сургалт зохион байгуулан явуулснаар төсвийн байгууллага бүрт шинэ соёл төлөвшүүлэх ажил хэрэгжиж байна.	70
	4	Төрийн албан дахь авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж энэ чиглэлээр үйлчилж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгоно	Төрийн албан дахь авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг Авилгатай тэмцэх газар, олон нийтийн бусад байгууллагууд, ялангуяа Ажил олгогч эздийн холбоо, төрийн бус байгууллагуудын сүлжээтэй хамтран жил бүрийн эхэнд төлөвлөгөө гаргаж төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж байна. Авилгатай тэмцэх газраас 2009 оны 10 дугаар сард авилгын эсрэг хууль, зарим хөтөлбөрүүд, гурвалсан гэрээний хэрэгжилтийг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтээр тус аймагт авилгын эсрэг хуулийг хэрэгжүүлэх, авилгатай тэмцэх соён гэгээрүүлэх ажлын явц байдлыг хангалттай гэж үнэлсэн. 2010 онд сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, албан газар байгууллагын дарга, эрхлэгч 79 хүнд “Авилгатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах төлөвлөгөө боловсруулах аргачлал” сэдэвт сургалт зохион байгуулж, дадлагын ажил хийлээ.	70

5	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлнэ	Монгол улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм” батлагдан гарлаа. Уг дүрмийг сумдын ЗДТГ, агентлагуудад олшруулан хүргүүлээ. Мөн энэ тухай төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарын шуурхай цуглаан болон аймгийн ЗДТГ-ын аппаратын мэдээллийн цаг хөтөлбөрөөр сургалт зохион байгуулж явууллаа. Энэхүү дүрэм болон Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолын дагуу төсвийн бүх байгууллагууд ажилтнуудынхаа ёс зүйн дүрмийг боловсруулж хамт олноороо хэлэлцүүлж батлан ажиллаж байна. Мөн төрийн албаны Зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам” – ыг хэрэгжүүлж Төсвийн байгууллага бүр ёс зүйн хороо байгуулан ажиллаж байна.	100
6	Төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шинээр болон шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлнэ	Төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагч бүхий байгууллагууд өөрсдийн салбарын албан хаагчдын ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байна. 2011 оноос эхлэн “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг жишиг болгон байгууллага тус бүр ажилтнуудынхаа ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж хамт олноороо хэлэлцүүлж батлан мөрдөн ажиллаж байна. Төсвийн байгууллага бүр баталсан ёс зүйн дүрмээ ажилтан бүрт олшруулж өглөө. Төсвийн байгууллага бүр ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих ёс зүйн хороо байгуулан ажиллаж байна.	100
4.5.6	6	Яамдын болон аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний ажилтнуудыг хяналт шинжилгээ үнэлгээ өндөр хөгжсөн орнуудын туршлага судлуулах, энэ чиглэлээрх гадаад дотоодын сургалтанд ээлж дараатай хамруулах замаар ажилтнуудыг чадваржуулж төрийн захиргааны байгууллагуудын хяналт шинжилгээ үнэлгээний онол арга зүйн түвшинг дээшлүүлнэ	70
4.5.7	2	Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуульд орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулна	100

	4	Орон нутгийн бие даасан байдлыг хангахад чиглэгдсэн жишиг (загвар) сум шалгаруулах болзол баталж хэрэгжүүлнэ	2009 оны 06 сарын сүүлчийн Засгийн газрын хуралдаанаар жишиг сумын болзол батлан гаргаж ирүүлсэн бүх сумдад хүргүүлээд байна. Манай аймгийн 19 сумаас жишиг багийн болзлын үзүүлэлт бүрийг ханган ажиллах талаар өөрийн сумын түвшинд санаачлан хийж жил бүрийн ажил дүгнэх үзүүлэлтээр харьцуулалт хийж үнэлэлт дүгнэлт өгч байна. Баруунтуруун сумыг газар тариалангийн загвар сум болгохоор шийдвэрлэн тодорхой ажлуудыг үе шаттайгаар хийж байна.	70
4.5.8	1	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан хүргүүлсэн болно.	100
4.5.10	1	Төрийн захиргааны төв, орон нутгийн захиргааны болон сонгосон зарим салбарын нийтлэг болон туслах чиг үүргийг хамарсан стратегийн чиг үүргийн шинжилгээг тусгай төлөвлөгөөний дагуу хийж чиг үүргийн давхардлыг арилгах, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох орон тоог цөөрүүлэх арга хэмжээ авна	Орон нутгийн засаг захиргааны болон бусад чиг үүргийн шинжилгээ судалгаа хийх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу явуулах давхардлыг арилгах ажлын ачааллыг жигдрүүлэх орон тоог цөөрүүлэх асуудлыг орон нутгийн түвшинд судлан шийдвэрлэх боломжийг судлаж байна. Ажил үүргийн давхардал хийдэгдлийг арилгаж, ажлын байрны тодорхойлолтыг 2010 онд шинэчлэн боловсруулж батлан мөрдөж байна. Мөн зарим ажлын байрыг цөөрүүлэх арга хэмжээ авч байна.	70
5.1.1	14	ОХУ, БНХАУ, АНУ, Канад, Япон, ХБНГУ, БНКаз улстай аймаг хотуудын шууд харилцаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	Хөрш зэргэлдээ ОХУ-ын Хакасс, Тува улстай найрсаг хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ОХУ-ын Хакасс, Тува улсын их дээд сургуульд 18 оюутан, Монгол улсын их дээд сургуульд ОХУ-аас 60 гаруй оюутанг суралцуулж, Тува улсын соёлын коллежид гэрээгээр 3 багшийг ажиллуулж, Тува улсын болон Хархираагийн хүүхдийн зусланд 30 хүүхдийг солилцон амрууллаа. Бизнесийн салбарын хүрээнд ОХУ-д 1300 тн мах экспортлож, 5400 тн гурил, 18.000тн шатах тослох материал, хүнсний болон өргөн хэрэглээний барааг ОХУ-аас импортоор авч, чацарганы 5 сортын 12.000 суулгац, үхрийн нүдний 4000, 6 сортын тэжээлийн ургамал, арвай, овъёос, гурвалжин будаа зэрэг 20 сортын таримал ургамлын үр авч нутагшуулан, өөрийн аймгийн төдийгүй зэргэлдээ аймгуудын хэрэгцээнд нийлүүлж байна. ШУӨЗО-ны Алтай, Цонж аймагтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. БНЭУ-ын Ладок мужтай төрийн албан хаагчийг мэргэшүүлэх чиглэлээр, Болгар улстай чацаргана хөтөлбөрөөр, Солонгосын Поско төмөрлөгийн үйлдвэртэй техник технологийн хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллах бэлтгэл хангаад байна. БНЭУ-д газар тариалангийн чиглэлээр 4 төрийн албан хаагчийг англи хэлний 6 сарын сургалтанд хамруулж 8 сая төгрөгний санхүүжилт гаргасан.	90
5.1.4	6	Хил бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх таатай нөхцлийг хангах талаар холбогдох талуудтай ажиллана	Хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар холбогдох байгууллагад саналаа хүргүүлэн сум хошуудыг шууд харилцаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн 6 сумыг Оросын холбооны Тува улсын хошуутай, 6 аж ахуйн нэгж байгууллага, 11 төрийн болон төрийн бус байгууллага үйл ажиллагааны	90

			<p>чиглэл нэг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээг шинээр байгуулан ажиллаж байна.</p> <p>Тува улсын Кызылын хэсгийн болон Монгол улсын Увс, Завхан, Баян-Өлгий, Хөвсгөлийн хэсгийн хилийн бүрэн эрхт төлөөлөгчдийн уулзалт зөвлөлгөөн, Тува улсын Дотоод Явдлын Яам болон Монгол улсын Увс, Баян-Өлгий, Завхан аймгуудын Цагдаагийн байгууллагын ажилтнуудын ажил хэргийн уулзалт зөвлөгөөнүүд Улаангом хотноо явагдсанаар малын хулгайтай тэмцэх чиглэлээр хил орчмын бүс нутгийн хилийн цэргийн болон цагдаагийн ажилтнуудын хүрээнд хамтран ажиллах мэдээлэл цаг алдалгүй солилцох бололцоо бий боллоо.</p> <p>2011 оны 12 сард аймгийн Засаг дарга Э.Цасчихэр тэргүүтэй 30 гаруй төлөөлөгчид Кызыл хотноо Тувагийн Засгийн газрын тэргүүний урилгаар ажлын айлчлал хийснээр хэд хэдэн тулгамдсан асуудлаар санал солилцож тодорхой шийдэлд хүрснээр хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурсан төдийгүй нийгэм, соёл урлаг, хууль хяналт, хүүхдийн болон шашны байгууллага, хөдөө аж ахуйн салбарт шинээр хамтын ажиллагааны гэрээ байгуулав.</p> <p>Хилийн яармаг худалдааг 2010 оны 6 сард зохион байгуулснаар Увс аймгийн төдийгүй Улаанбаатар, Завхан, Баян-Өлгий, Ховд зэрэг аймгийн 4000 гаруй бизнес эрхлэгч, ОХУ-ын Тува, Хакасс, Алтай улсын 3200 гаруй бизнес эрхлэгчид оролцон 3 тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийлээ.</p> <p>Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд харилцан туршлага судлах ,мэргэжилтэн солилцох ажиллуулах , оюутан сургах, жуулчин солилцох зэрэг ажлыг хийж байгаа бөгөөд цаашид хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд анхааран ажиллаж байна.</p>	
5.2.7	1	Дайчилгааны I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын чанар оролцох бүрэлдэхүүнийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ	<p>2010 оны 6 дугаар сарын 21-нээс 30-ны хооронд Баруунтуруун суманд цэргийн чухал мэргэжил бүхий 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 60 хүний сургалт зохион байгуулж явуулсан. Мөн цэргийн дүйцүүлэх албаны 71 хүний сургалтыг Улаангом суманд зохион явуулсан.</p> <p>2011 онд 90 хүний сургалт зохион байгуулахаар төлөвлөгөөнд оруулсан.</p>	100

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын товчоо

№	Нийт заалтын тоо	100%	90%	70%	50%	30%	10%	0%
1	96 зорилтын 170 заалт	15	26	49	48	26	5	1
	Дундач хувь	61,8%						

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

